НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО (ISO 9001:2015, ISO 21001:2018)-НЫ ГАРЫН АВЛАГА

Байгууллагын нэр	Монгол улсын их сургууль (МУИС)
Байгууллагын хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж–1, Бага тойруу, 14201, Монгол Улсын Их сургууль хичээлийн I байр
Баримт бичгийн №	NUM/EOMS/001
Шинэчилсэн хувилбар №	02
Шинэчилсэн огноо	2026.10.26
Өмнөх хувилбар	2025-07-21

АГУУЛГА

[A] БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН ТҮҮХ 5
[B] МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА 5
[C] ОРШИЛ 6
[D] ХАМРАХ ХҮРЭЭ 8
[E] НОРМАТИВ ИШ ТАТАЛТ 8
[F] НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ 8
[G] НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ /АНГЛИ, МОНГОЛ/ 10
БҮЛЭГ 4: БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ (ISO 21001:2018, ISO 9001:2015) 12
4.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох 12
4.1.1 Макро Орчны Шинжилгээ (PESTEL) 12
4.1.2 Микро Орчны Шинжилгээ (SWOT) 13
4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох 15
4.2.1. МУИС-ийн сонирхогч талууд 15
4.2.2. МУИС-ийн сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт 15
4.2.3. Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийн хяналт 16
4.3 Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох 17
4.4 Нэгдсэн менежментийн тогтолцоо ба түүний үйл явц 17
БҮЛЭГ 5: МАНЛАЙЛАЛ 19
5.1 Манлайлал ба амлалт 19
5.1.1 Ерөнхий зүйл 19
5.1.2 Суралцагч болон бусад үйлчлүүлэгчдэд төвлөрөх 19
5.1.3 Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага 20
5.2 Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого 20
5.2.1. Бодлого боловсруулах 20
5.2.2. Бодлогыг мэдээлэх 20
5.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл 21
БҮЛЭГ 6. ТӨЛӨВЛӨЛТ 22
6.1. Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээ 22
6.2. Нэгдсэн менежментийн тогтолцооны зорилт, түүнд хүрэх төлөвлөлт 22
6.3. Өөрчлөлтийг төлөвлөх 23
БҮЛЭГ 7. ТУЛГУУР ХҮЧИН ЗҮЙЛ 24
7.1. Нөөц 24
7.1.1. Ерөнхий зүйл 24
7.1.2. Хүний нөөц 24
7.1.3. Дэд бүтэц 25
7.1.4. Үйл явцыг хэрэгжүүлэх орчин 26

7.1.5. Мониторинг, хэмжилтийн нөөц 27
7.1.6. Байгууллагын мэдлэг 27
7.2. Чадамж 28
7.2.1. Ерөнхий зүйл 28
7.2.2. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага 29
7.3. Мэдлэг, ойлголт 30
7.4. Харилцаа холбоо 30
7.4.1. Ерөнхий зүйл 30
7.4.2. Харилцаа холбооны зорилго 31
7.4.3. Харилцаа холбооны зохицуулалт 31
7.5. Баримтжуулсан мэдээлэл 31
7.5.1. Ерөнхий зүйл 31
7.5.2. Баримтжуулсан мэдээллийг бий болгох, шинэчлэх 32
7.5.3. Баримтжуулсан мэдээллийн хяналт 32
БҮЛЭГ 8. АЖИЛЛАГАА 33
8.1. Ажиллагааны төлөвлөлт ба хяналт 33
8.1.1. Ерөнхий зүйл 33
8.1.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний тусгай ажиллагааны төлөвлөлт ба хяналт 33
8.1.3. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага 34
8.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага 34
8.2.1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох 34
8.2.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг мэдээлэх 35
8.2.3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагыг хянан үзэх, өөрчлөх 35
8.3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт 36
8.3.1. Ерөнхий зүйл 36
8.3.2. Дизайн ба боловсруулалтын төлөвлөлт 36
8.3.3. Дизайн ба боловсруулалтын орц 37
8.3.4. Дизайн ба боловсруулалтын хяналт 37
8.3.5. Дизайн ба боловсруулалтын гаралт 39
8.3.6. Дизайн ба боловсруулалтын өөрчлөлт 39
8.4. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт 40
8.4.1. Ерөнхий зүйл 40
8.4.2. Хяналтын төрөл ба цар хүрээ 40
8.4.3. Гаднын нийлүүлэгчид өгөх мэдээлэл 41
8.5. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх 41
8.5.1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхэд тавих хяналт 41
8.5.2. Тэмдэглэгээ ба мөшгөх боломж 45

8.5.3. Сонирхогч талын өмч 45
8.5.4. Хамгаалалт 45
8.5.5. Суралцагчдын өгөгдлийн хамгаалалт, ил тод байдал 45
8.5.6. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийн хяналт 46
8.6. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах 46
8.7. Үл тохирол бүхий гаралтын хяналт 46
БҮЛЭГ 9. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 48
9.1. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээ 48
9.1.1. Ерөнхий зүйл 48
9.1.2. Суралцагч, бусад үр шим хүртэгч талууд болон ажилтнуудын сэтгэл ханамж 48
9.1.3. Бусад мониторинг, хэмжилтийн хэрэгцээ 50
9.1.4. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний арга 51
9.1.5. Дүн шинжилгээ ба үнэлгээ 51
9.2. Дотоод аудит 51
9.3. Удирдлагын дүн шинжилгээ 52
9.3.1. Ерөнхий зүйл 52
9.3.2. Удирдлагын дүн шинжилгээний оролт 52
9.3.3. Удирдлагын дүн шинжилгээний гаралт 53
БҮЛЭГ 10. САЙЖРУУЛАЛТ 54
10.1. Ерөнхий зүйл 54
10.2. Үл тохирол ба залруулах арга хэмжээ 54
10.3. Тасралтгүй сайжруулалт 54
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ 56

[A] БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН ТҮҮХ

Хяналтын дугаар	Бүлгийн дугаар	Хуудасны дугаар	Одоогийн хяналтын дугаар	Шинэчлэх огноо	Өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	Баримт бичгийн өөрчлөлтийн мэдэгдлийн дугаар
01	Бүх бүлэг	Бүх хуудас	01	2025.07.21	Баримт бичгийг анх боловсруулж, баталсан.	—
02	Бүх бүлэг	Холбогдох хуудсууд	02	2026.10.26	ISO 21001:2018 болон ISO 9001:201 стандартын уялдааг шинэчилж, НМТ-ийн хамрах хүрээ, нэр томьёо, холбогдох баримт бичгийн эшлэлийг нийцүүлэн засварлав.	—

[B] МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь 1942 онд байгуулагдсан, Монгол Улсын ууган бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж буй үндэсний хэмжээний их сургууль юм.

МУИС нь:

- Бүрэлдэхүүн 8 сургууль,
- Орон нутаг дахь 3 салбар сургууль,
- Судалгааны 9 хүрээлэн, төв
- Бие даасан 7 нэгж, төв болон дэмжих чиг үүрэг бүхий бусад нэгжүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

МУИС бакалавр, магистр, докторын түвшний боловсрол олгохоос гадна эрдэм шинжилгээ, судалгааны өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа эрхэлж, эрдэмтэн багш, ажилтан, суралцагчдынхаа хамтаар Монгол Улсын эрдэм оюуны хөгжлийг манлайлан чиглүүлж байна. МУИС нь 80 гаруй жилийн түүхэн уламжлал, туршлагынхаа үндсэн дээр өнөөдөр Монголын дээд боловсролын салбарын хөгжилд тэргүүлэх байр суурь эзэлж, шинжлэх ухаан, боловсролын олон улсын түвшний хамтын ажиллагааг өргөжүүлэн, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай мэдлэгт суурилсан их сургууль болох зорилт тавин ажиллаж байна.

МУИС нь байгуулагдсан цагаасаа Монгол Улсын дээд боловсрол, шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулж, сургалт, судалгаа, байгууллагын удирдлага, зохион байгуулалтаа хөгжлийн үе шат бүрд шинэчлэн ирсэн

2026–2027 оны хичээлийн жилд МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар 11 сургуульд бакалавр, магистр, докторын түвшний нийт 337 сургалтын хөтөлбөр, үүнээс 44 хамтарсан хөтөлбөр хэрэгжиж байна. Нийт 66 хөтөлбөр үндэсний хэмжээнд, 10 хөтөлбөр олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд 29,719 суралцагч, 1,300 гаруй багш, ажилтантайгаар сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа болон бусад үйл ажиллагаагаа явуулж байна.

МУИС-ийн 2025–2030 оны стратеги төлөвлөгөөнд сургалт, судалгааны чанар, олон улсын хамтын ажиллагаа, сургалт, судалгааны орчин, байгууллагын засаглал, удирдлагын үр нөлөөг сайжруулах чиглэлүүдийг тусгасан. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд ISO 21001:2018 болон ISO 9001:2015 стандартын шаардлагад нийцсэн нэгдсэн менежментийн тогтолцоо нь үйл ажиллагааны уялдаа, гүйцэтгэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлага, тасралтгүй сайжруулалтыг дэмжих хэрэгсэл болж байна.

[C] ОРШИЛ

Энэхүү гарын авлага нь Монгол Улсын Их Сургуульд ISO 21001:2018 болон ISO 9001:2015 стандартын шаардлагад үндэслэн хэрэгжүүлж буй Нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) бүтэц, үйл явц, тэдгээрийн харилцан уялдаа, удирдлага болон сайжруулалтын зохицуулалтыг тайлбарлах үндсэн баримт бичиг мөн.
МУИС-ийн нэгж, бүрэлдэхүүн, салбар сургууль, захиргаа аж ахуйн нэгжүүдийн заавал мөрдөх бодлого, журмын эмхэтгэлийн тойм болж буй энэхүү гарын авлага нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн дараах зорилгыг агуулна. Үүнд:

- НМТ-ны бүтцийг тодорхойлох: МУИС-ийн НМТ-ны үйл явц, тэдгээрийн харилцан хамаарал, нэгжүүдийн хоорондох хариуцлагын хуваарилалтыг тодорхой тайлбарлах;
- Чадамжийг батлах: Суралцагчид болон бусад үр шим хүртэгчдийн хэрэгцээ шаардлага, мөн зохицуулалтын шаардлагыг бүрэн хангах МУИС-ийн чадварыг баталгаажуулах;
- Тасралтгүй сайжруулалтыг дэмжих: Тогтолцооны үр дүнтэй байдлыг хангаж, суралцагч болон сонирхогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сайжруулалтын үйл явцыг тогтмол дэмжих.

Энэхүү гарын авлагад дурдсан бодлого, журам нь МУИС-ийн бүх түвшинд үр дүнтэй, үр ашигтай үйл ажиллагааг дэмжиж, байгууллагын чиг үүргийг стандартчилах, хялбарчлах үндэс болно. Үүний үр дүнд чанартай боловсролын үйлчилгээг тогтвортой хүргэх, байгууллагын урт хугацааны хөгжлийг хангах боломж бүрдэнэ.

АЛСЫН ХАРАА

Дэлхийн түвшний судалгааны их сургууль болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид шинжлэх ухааны хөгжлийн үндэсний түүчээлэгчийн хувьд эрдэм шинжилгээ, сургалтаар манлайлж, нийгмийг хөгжүүлэгч хүч болсон тэргүүлэх их сургууль байна.

ҮНЭТ ЗҮЙЛС:

МУИС-ийн НМТ-ны хэрэгжилт нь дараах үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлана.


- Академик Эрх Чөлөө: Оюуны чөлөөт, нээлттэй эрэл хайгуул хийх, түүний үр дүнг чөлөөтэй илэрхийлэхийг бүх талаар дэмжиж, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх.
- Ёс Зүй: Багш, судлаач, оюутны болон хувь хүний ёс зүйг дээдлэн, үнэнч шударга байж, бусдад хүндэтгэлтэй хандах.
- Уламжлалын Бахархал: Дээд боловсролын анхдагч, шинжлэх ухааны суурь салбарыг хөгжүүлэгч МУИС-аар овоглосон хэн бүхний бахархлыг бадраах.
- Бүтээлч Байдал: Бүтээлч сэтгэлгээгээр инновацлаг шийдэл, өөрчлөлтийг дэмжин, үр дүнд төвлөрч бүтээмжтэй ажиллах.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх стратегийн тэргүүлэх таван чиглэл нь НМТ-ны бодлого, зорилтуудын үндэс болно.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1.ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ – Судалгаа, инновацын чадамжийг бэхжүүлнэ.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2.СУРГАЛТ - Дэлхийд өрсөлдөх чадвартай оюунлаг иргэдийг бэлтгэнэ.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.НИЙГМИЙН ОРОЛЦОО – Хамтын ажиллагаагаар нийгэмд тогтвортой үнэ цэнийг бүтээнэ.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.НӨӨЦ – Байгууллагын нөөцийн оновчтой удирдлагыг хөгжүүлнэ.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5.ЗАСАГЛАЛ – Сайн засаглалыг төлөвшүүлж, менежментийн чадамжийг бэхжүүлнэ.

МУИС-ИЙН 2025-2030 ОНЫ СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТУУД



МУИС-ИЙН НМТ-НЫ ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

МУИС-ийн НМТ-ны бодлого нь алсын хараа, эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд найдвартай, өндөр чанартай боловсрол, сургалт, судалгаа болон бусад үйлчилгээгээр сонирхогч, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангаж, үндэсний хэмжээнд баталгаажсан байр сууриа бэхжүүлэн, олон улсад өрсөлдөх чадвараа тасралтгүй үнэлж сайжруулахад чиглэнэ.

МУИС нь оюутан, багш, ажил олгогч, үйлдвэрлэл эрхлэгч, төрийн байгууллага, олон нийтийн нийтлэг хэрэгцээ, хүлээлтэд байнга анхаарч, холбогдох бүх шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна боловсролын байгууллагын менежментийн тогтолцоогоо байнга сайжруулж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, оюуны өмчийг эрхэмлэн ажиллана.

МУИС-ийн боловсролын бодлого дараах чиглэлд төвлөрнө:

- Боловсролын инновацыг ашиглан оюутнуудад үндэсний болон олон улсын түвшинд өрсөлдөхүйц, өндөр чанартай, өргөн цар хүрээтэй мэдлэг, эрдмийн зэрэг эзэмших боломж бүрдүүлнэ;
- Үйл ажиллагаагаа төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх бүх шатанд оюутан болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангана;
- Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх зорилгод нийцсэн боловсролын үйлчилгээгээр нийгэмд үр өгөөжөө хүргэнэ;
- Оролцогч талуудын идэвхтэй оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж мэргэжилтнүүдэд тасралтгүй боловсрол олгоно;
- Олон улсын дээд боловсролын зах зээлд өрсөлдөх чадвараа бэхжүүлнэ;
- Багш, ажилтнуудаа тогтвортой ажлын байр, аюулгүй эрүүл орчин, мэргэжлийн хөгжлийн боломжуудаар хангана;
- Ёс зүйд нийцээгүй аливаа үйл ажиллагааг хориглон, эрдэм шинжилгээний бүрэн бүтэн байдал, эрдмийн эрх чөлөөг хамгаална;
- Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчинэ.

[D] ХАМРАХ ХҮРЭЭ

НМТ-ийн хамрах хүрээг “МУИС-ийн НМТ-ийн хамрах хүрээ” (Хувилбар 02) баримт бичгээр тодорхойлно. Тус баримт бичигт хамрагдах үйл ажиллагаа, үйлчилгээ, нэгж, байршил болон хамрах хүрээнээс гадуурх нэгжүүдийг заасан бөгөөд энэхүү гарын авлагыг уг баримт бичигтэй хамтатган хэрэглэнэ.

- НМТ-ийн тогтоосон хамрах хүрээнд ISO 21001:2018 болон ISO 9001:2015 стандартын шаардлагын хэрэглэгдэх байдлыг хамрах хүрээний баримт бичгийн 5.6-д тодорхойлсон. Тогтолцооны үйл явц бүрт холбогдох шаардлагыг хэрэгжүүлнэ.
- НМТ-г үр дүнтэй хэрэгжүүлэх ерөнхий үүрэг, хариуцлагыг Менежментийн баг хүлээнэ.

[E] НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

Баримт бичиг	Хувилбар	Гарчиг
ISO 21001	2018	Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо - Ашиглах заавар бүхий шаардлага
ISO 9001	2015	Чанарын менежментийн тогтолцооны шаардлага

[F] НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

Тогтолцоотой холбоотой нэр томьёо	
Шаардлага	Ерөнхийдөө зөвшөөрөгдсөн буюу албан журмын шинжтэй, тогтоосон хэрэгцээ буюу хүлээлт
Шинж чанар	Ялгагдах онцлог
Мөшгөгдөх байдал	Объектын байршил, хэрэглээ эсвэл түүх мөшгөх чадвар
Тогтолцоо	Харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй элементүүдийн багц
Менежментийн тогтолцоо	Бодлого ба зорилтуудыг тодорхойлох, харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй, байгууллагын элементүүдийн багц ба тэдгээр зорилтуудыг хангах үйл явцууд
EOMS/ББМТ	ISO 21001:2018 стандартын боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо.
ЧМТ (QMS)	ISO 9001:2015 стандартын чанарын менежментийн тогтолцоо
НМТ (IMS)	МУИС эдгээр хоёр тогтолцоог нэгтгэн хэрэгжүүлж буй нэгдсэн менежментийн тогтолцоо.

НМТ-ны бодлого	Дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн НМТ-ны гүйцэтгэлтэй холбоотой байгууллагын ерөнхий зорилго, чиглэл
НМТ-ны зорилт	Байгууллагын зорилгод хүрэхийн тулд НМТ-ны гүйцэтгэлийн зорилт
Менежмент	Байгууллагыг удирдан чиглүүлэх, хянах үйл ажиллагааг зохицуулах.
Дээд удирдлага	Байгууллагыг дээд түвшинд удирдан чиглүүлж, хянадаг хувь хүн ба бүлэг хүмүүс
Байнгын сайжруулалт	Шаардлагыг биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд давтагдах үйл ажиллагаа
Үр дүнтэй байдал	Төлөвлөсөн ажлууд хэр биелж, төлөвлөсөн үр дүнд хүрч байгаа байдал
Үр ашиг	Хүрсэн үр дүн ба ашигласан нөөцийн хоорондын хамаарал
Байгууллагатай холбоотой нэр томьёо	
Байгууллага	Өөрийн зорилтод хүрэхийн тулд чиг үүрэг, үүрэг хариуцлага, эрх мэдэл, харилцан хамаарал бүхий хувь хүн ба бүлэг хүмүүс
Байгууллагын бүтэц	Үүрэг, хариуцлага, эрх мэдэл, хүмүүсийн хоорондын харилцааны зохицуулалт
Дэд бүтэц	Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээтэй байгууламж, тоног төхөөрөмж, үйлчилгээнүүдийн зохион байгуулалтын тогтолцоо
Ажиллах орчин	Ажил хийж гүйцэтгэх нөхцөл байдлын багц
Нийлүүлэгч	Бүтээгдэхүүн нийлүүлдэг байгууллага эсвэл хүн
Сонирхогч тал	Байгууллагын гүйцэтгэл эсвэл амжилтад сонирхолтой хүн эсвэл бүлэг
Үйл явц ба бүтээгдэхүүнтэй холбоотой нэр томьёо	
Үйл явц	Орцыг гаралт болгон хувиргадаг харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлийн багц
Бүтээгдэхүүн	Үйл явцын үр дүн
Төсөл	Цаг хугацаа, зардал, нөөцийн хязгаарлалт зэрэг тодорхой шаардлагад тохирсон зорилгод хүрэхийн тулд эхлүүлсэн болон дуусах огноо бүхий зохицуулалттай, хяналттай үйл ажиллагаанаас бүрдэх өвөрмөц үйл явц.
Журам	Үйл ажиллагаа эсвэл үйл явцыг хэрэгжүүлэх тодорхой арга зам.
Ажлын заавар	Үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх тухай бичгээр зааварчилгаа.
Тохиролтой холбоотой нэр томьёо	
Тохирол	Шаардлагын биелэлт
Үл тохирол	Шаардлагыг биелүүлэхгүй байх
Согог	Зориулалтын болон заасан ашиглалттай холбоотой шаардлагыг биелүүлээгүй.
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Боломжит үл тохирол эсвэл бусад хүсээгүй нөхцөл байдлын шалтгааныг арилгах арга хэмжээ.
Залруулах арга хэмжээ	Илэрсэн үл тохирол болон бусад хүсээгүй нөхцөл байдлын шалтгааныг арилгах арга хэмжээ
Залруулга	Илэрсэн үл тохирлыг арилгах арга хэмжээ
Гаргах зөвшөөрөл /Release/	Үйл явцын дараагийн үе шатанд шилжүүлэх, эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид хүргэх зөвшөөрөл
Баримт бичигтэй холбоотой нэр томьёо	
Мэдээлэл	Ач холбогдол бүхий өгөгдөл
Баримтжуулсан мэдээлэл / Баримт бичиг	Байгууллага хянаж бас мөрдөж хадгалах шаардлагатай мэдээлэл ба түүнийг агуулж буй баримт бичиг
Үзүүлэлтүүд	Шаардлагыг тодорхойлсон баримт бичиг

IMS /НМТ гарын авлага	ISO 21001:2025, ISO 9001:2015 стандартад заасан шаардлагыг хангах байгууллагын менежментийн нэгдсэн тогтолцоог тодорхойлсон баримт бичиг /МУИС-ийн дотоод хэрэглээний тодорхойлолт/
Хадгалагдсан мэдээлэл / Бүртгэл	Хүрсэн үр дүнг харуулсан баримт бичиг эсвэл гүйцэтгэсэн үйл ажиллагааны нотлох баримт
Шалгалттай холбоотой нэр томьёо	
Объектив нотолгоо	Аливаа зүйлийн оршин байгаа эсвэл үнэн эсэхийг батлах өгөгдөл
Магадалгаа /Verification	Тодорхой шаардлагыг хангасан болохыг бодитой нотлох баримтаар магадлах
Шинжлэх	Зорилгодоо хүрэхийн тулд тухайн сэдвийн зохистой байдал, хүрэлцээ, үр нөлөөг тодорхойлоход чиглэсэн үйл ажиллагаа
Аудиттай холбоотой нэр томьёо	
Аудит	Аудитын шалгуурыг хэр хангаж байгааг тодорхойлохын тулд аудитын нотлох баримтыг олж авах, бодитойгоор үнэлэх системтэй, хараат бус, баримтжуулсан үйл явц.
Аудитын хөтөлбөр	Тодорхой хугацаанд төлөвлөсөн, тодорхой зорилгод чиглэсэн нэг буюу хэд хэдэн аудитын багц.
Аудитын шалгуур	Лавлагаа болгон ашигласан бодлого, журам эсвэл шаардлагын багц
Аудитын нотолгоо	Аудитын шалгуурт нийцсэн, шалгах боломжтой бүртгэл, баримтын мэдэгдэл эсвэл бусад мэдээлэл.
Аудитын үр дүн	Цуглуулсан аудитын нотлох баримтыг аудитын шалгуурын дагуу үнэлсний үр дүн.
Аудитын дүгнэлт	Аудитын зорилтууд болон аудитын бүх үр дүнг авч үзсэний дараа аудитын багийн өгсөн аудитын үр дүн.
Аудитлагдагч	Аудитад хамрагдаж буй байгууллага, нэгж, үйл ажиллагаа
Аудитор	Аудит хийх чадвартай хүн.
Аудитын баг	Аудит гүйцэтгэхээр томилогдсон нэг буюу хэд хэдэн аудитор
Техникийн шинжээч	Аудитад хамрагдах сэдвийн талаар тодорхой мэдлэг, туршлагатай хүн.
Чадамж	Мэдлэг, ур чадвараа ашиглах
IMS-той холбоотой нэр томьёо	
НМТ гүйцэтгэл	Байгууллагын НМТ-ны эрсдэлийн менежментийн хэмжигдэхүйц үр дүн.
Эрсдэл	Тодорхой бус байдлын нөлөө
Ажлын байр	Байгууллагын хяналтын дор холбоотой үйл ажиллагаа явуулдаг аливаа физик байршил.
Хэрэглэгч	Боловсролын үйлчилгээ, бүтээгдэхүүн, үр шимийг шууд болон шууд бус байдлаар хүртэж буй бүх талуудыг хэлнэ.
Суралцагч	Дэд бакалавр болон бакалаврын хөтөлбөрийн оюутан, магистрын хөтөлбөрийн магистрант, докторын хөтөлбөрийн докторант.
Боловсролын үйлчилгээ	Боловсролын байгууллагаас суралцагчид мэдлэг, чадвар, ёс суртахуун эзэмшүүлэх, тэднийг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй зохион байгуулалттай, бодит бус (хийсвэр) шинж чанартай үйл ажиллагаа

[G] НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ /АНГЛИ, МОНГОЛ/

Товчлол	Утга
Дээд удирдлага	Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл
IP	Interested Party / Сонирхогч тал
IL	Issue Log/ Асуудлын бүртгэл
EOMSP	EOMS Procedures-НМТ-ны журмууд

EOMS/ББМТ	Educational Organizations Management System - Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо
QMS/ЧМТ	Quality Management System - Чанарын менежментийн тогтолцоо
IMS/НМТ	Integrated Management System - Нэгдсэн менежментийн тогтолцоо
MR	Management Representative - Удирдлагын төлөөлөгч
FH	Functional Heads /Функциональ нэгжийн дарга/ Ректор, проректорууд, нэгжийн дарга нар, сургуулийн захирлууд, эрдмийн зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн дарга,
NCR	Nonconformity Report - Үл тохирлын тайлан
NC	Nonconformity — Үл тохирол
CN	Change Notification — Өөрчлөлтийн мэдэгдэл

БҮЛЭГ 4: БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1 Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны зорьсон үр дүнд хүрэхэд нөлөөлж болох дотоод болон гадаад асуудлуудыг байгууллагын эрхэм зорилго, стратегийн зорилт, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа болон бусад үйл ажиллагааны онцлогтой уялдуулан тодорхойлж, үнэлдэг.

Байгууллагын төлөв байдлыг тодорхойлохдоо улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, байгаль орчин, хууль эрх зүйн хүчин зүйлсийг PESTEL шинжилгээний аргаар, байгууллагын дотоод давуу болон сул тал, гадаад боломж, аюул заналыг SWOT шинжилгээний аргаар тус тус үнэлнэ.

МУИС-ийн нэгдсэн менежментийн тогтолцоонд нөлөөлөх гадаад асуудлуудад дээд боловсролын бодлого, хууль эрх зүйн өөрчлөлт, санхүүжилтийн нөхцөл, хүн ам зүйн өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, технологийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс хамаарна.

Дотоод асуудлуудад байгууллагын засаглал, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх, сургалт, судалгааны чанар, санхүүгийн болон материаллаг нөөц, дэд бүтэц, мэдээллийн систем, байгууллагын соёл, үйл явцын уялдаа, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг хүчин зүйлсийг авч үзнэ.

Эдгээр асуудлын өөрчлөлт, нэгдсэн менежментийн тогтолцоонд үзүүлэх нөлөөг холбогдох нэгжүүдийн мэдээлэл, стратегийн төлөвлөгөөний хэрэгжилт, эрсдэл ба боломжийн үнэлгээ, дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилнэ.

Байгууллагын төлөв байдлын шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг холбогдох бүртгэл, шинжилгээний баримт бичигт тусган хадгална.

4.1.1 Макро Орчны Шинжилгээ (PESTEL)

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны зорилго, төлөвлөсөн үр дүнд нөлөөлж болох гадаад орчны асуудлуудыг улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, байгаль орчин, хууль эрх зүйн хүчин зүйлсийн хүрээнд авч үздэг.

1. Улс төрийн хүчин зүйл (Political)

- **Боловсролын бодлого, шинэчлэл:** Дээд боловсролын салбарын бодлого, хөгжлийн чиглэл, төрөөс баримтлах тэргүүлэх чиглэлийн өөрчлөлт нь МУИС-ийн стратегийн төлөвлөлт, сургалт, судалгаа болон удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлж болно.
- **Бодлогын залгамж чанар:** Боловсролын бодлогын хэрэгжилтийн тогтвортой байдал, удирдлагын болон зохицуулалтын өөрчлөлтөөс үүдэх нөлөөллийг харгалзан үзнэ.

2. Эдийн засгийн хүчин зүйл (Economic)

- **Санхүүжилтийн нөхцөл**: Улсын төсвийн бодлого, сургалтын төлбөрийн орлого, судалгаа болон бусад эх үүсвэрийн санхүүжилт нь байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал, хөгжлийн боломжид нөлөөлнө.
- **Зардал, нөөцийн хүрэлцээ:** Инфляц, бараа үйлчилгээний үнийн өөрчлөлт, тоног төхөөрөмж болон дэд бүтцийн зардал нь санхүүгийн төлөвлөлт, нөөцийн хуваарилалтад нөлөөлж болно.

3. Нийгмийн хүчин зүйл (Social)

- **Хүн ам зүй, элсэлтийн орчин:** Хүн амын бүтэц, шилжилт хөдөлгөөн, элсэгчдийн хэрэгцээ, сонголтын өөрчлөлт нь сургалтын хөтөлбөр, элсэлтийн төлөвлөлтөд нөлөөлнө.
- **Суралцагч болон хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ:** Суралцагчдын хүлээлт, хөдөлмөрийн зах зээлийн ур чадварын эрэлт, насан туршийн суралцах хэрэгцээ нь сургалтын агуулга, арга хэлбэр, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах шаардлагыг бий болгоно.

4. Технологийн хүчин зүйл (Technological)

- **Цахим шилжилт:** Сургалт, судалгаа, захиргааны үйл ажиллагаанд цахим систем, мэдээллийн технологийг ашиглах хэрэгцээ нэмэгдэж байгаа нь үйл ажиллагааны хүртээмж, үр ашиг, мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлнө.
- **Шинэ технологийн хөгжил:** Хиймэл оюун ухаан, цахим сургалтын платформ, судалгааны шинэ технологийн хөгжил нь сургалт, үнэлгээ, судалгаа болон ажилтнуудын чадавхыг хөгжүүлэх шинэ хэрэгцээ, боломжийг бий болгоно.

5. Байгаль орчны хүчин зүйл (Environmental)

- **Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны нөхцөл:** Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол, цаг агаарын эрс тэс нөхцөл нь сургалт, судалгаа, байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдал, аюулгүй орчинд нөлөөлөх эсэхийг авч үзнэ.
- **Нөөцийн зохистой хэрэглээ:** Эрчим хүч, ус, материаллаг нөөцийн хэрэглээ, хог хаягдлын менежмент нь байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагатай холбоотой асуудал болно.

6. Хууль эрх зүйн хүчин зүйл (Legal)

- **Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага:** Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллах шаардлагатай.
- **Стандарт, магадлан итгэмжлэл:** Боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагууд нь байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн үнэлгээ, сайжруулалтын үйл явцтай уялдана.

Дүгнэлт

Гадаад орчны дээрх хүчин зүйлс нь МУИС-ийн стратегийн зорилт, сургалт, судалгаа, үйлчилгээний чанар, нөөцийн төлөвлөлт болон нэгдсэн менежментийн тогтолцооны үр нөлөөнд нөлөөлж болох тул тэдгээрийн өөрчлөлтийг байгууллагын төлөвлөлт, эрсдэл ба боломжийн үнэлгээ, удирдлагын дүн шинжилгээний хүрээнд харгалзан үзнэ.

4.1.2 Микро Орчны Шинжилгээ (SWOT)

МУИС нь байгууллагын стратегийн төлөвлөгөө, үйл ажиллагааны онцлог, өмнөх нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах давуу тал, сул тал, боломж, аюул заналыг дараах чиглэлээр авч үзнэ.

Давуу тал (Strengths)

- Монгол Улсын ууган их сургуулийн хувьд сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний олон жилийн туршлага, байгууллагын нэр хүнд, төгсөгчдийн өргөн сүлжээтэй.
- Олон салбарын сургалт, судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, мэргэшсэн багш, судлаачдын хүний нөөц, судалгааны хүрээлэн, төв, лабораторийн бүтэцтэй.
- Бакалавр, магистр, докторын түвшний сургалтын хөтөлбөрүүд, үндэсний болон олон улсын хамтын ажиллагааны туршлагатай.
- Сургалт, судалгаа, оюутны хөгжил, чанарын баталгаажуулалт, байгууллагын удирдлагыг дэмжих бүтэц, үйл ажиллагаатай.
- ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагыг уялдуулан хэрэгжүүлэх менежментийн тогтолцоотой.

Сул тал (Weaknesses)

- Стратегийн зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналын уялдааг цаашид сайжруулах хэрэгцээ.
- Сургалтын хөтөлбөр, сургалтын арга хэлбэрийг хөдөлмөрийн зах зээл, суралцагчдын өөрчлөгдөж буй хэрэгцээтэй тогтмол уялдуулах шаардлага.

- Багш, ажилтны мэргэжлийн хөгжил, карьерын төлөвлөлт, чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх хэрэгцээ.
- Гадаад хамтын ажиллагааны гэрээ, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээг сайжруулах шаардлага.
- Байгууллагын хэмжээнд үйл явцын уялдаа, мэдээллийн нэгдмэл байдал, гүйцэтгэлийн хяналт, үнэлгээний арга хэрэгслийг тасралтгүй боловсронгуй болгох хэрэгцээ.

Боломж (Opportunities)

- Судалгааны их сургуулийн хөгжлийг дэмжих бодлого, судалгаа, инновацын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж.
- Олон улсын хамтарсан, хос болон бусад уян хатан сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлэх боломж.
- Цахим сургалт, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологийн дэвшлийг сургалт, судалгаа, удирдлагын үйл ажиллагаанд ашиглах боломж.
- Насан туршийн суралцахуй, мэргэжил дээшлүүлэх болон зэргийн бус сургалтын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ нэмэгдүүлэх боломж.
- Төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага, их сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, судалгаа, хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх боломж.

Аюул (Threats)

- Дотоод, гадаадын их сургуулиудын өрсөлдөөн нэмэгдэх, элсэгчдийн сонголт, шилжилт хөдөлгөөн өөрчлөгдөх эрсдэл.
- Санхүүжилтийн нөхцөл, үйл ажиллагааны зардал, инфляцын өөрчлөлтөөс нөөцийн хүрэлцээнд үзүүлэх сөрөг нөлөө.
- Багш, судлаач, мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөөнөөс хүний нөөцийн тогтвортой байдалд үүсэх эрсдэл.
- Технологийн хурдацтай өөрчлөлтөөс сургалт, судалгаа, мэдээллийн системд тавигдах шаардлага нэмэгдэх, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл.
- Боловсролын бодлого, хууль эрх зүйн болон бусад зохицуулалтын өөрчлөлтөөс байгууллагын төлөвлөлт, хэрэгжилтэд үзүүлэх нөлөө.

Дүгнэлт

МУИС нь сургалт, судалгааны туршлага, хүний нөөц, байгууллагын нэр хүнд, олон талт хамтын ажиллагааны давуу талдаа тулгуурлан хөгжлийн боломжуудаа ашиглахын зэрэгцээ үйл ажиллагааны уялдаа, хүний нөөцийн хөгжил, сургалтын чанар, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг чиглэлээр сайжруулалт хийх хэрэгцээг харгалзан үзнэ.

SWOT шинжилгээнд тодорхойлсон асуудлуудыг стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, эрсдэл ба боломжийн үнэлгээ, нэгдсэн менежментийн тогтолцооны сайжруулалтын үйл ажиллагаатай уялдуулна.

Гадаад, дотоод асуудлын хяналт, шинэчлэл

МУИС нь байгууллагын гадаад болон дотоод асуудлууд, тэдгээрийн өөрчлөлтийг жилд нэгээс доошгүй удаа удирдлагын дүн шинжилгээний хурлаар авч үзэх бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд шаардлагатай үнэлгээ, шинэчлэлийг тухай бүр хийнэ.

Холбогдох баримт бичиг:

Гадаад болон дотоод асуудлын бүртгэл – (NUM/EOMS/FMT/14)

4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох

МУИС нь ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагын дагуу нэгдсэн менежментийн тогтолцооны зорьсон үр дүнд хүрэхэд нөлөөлөх сонирхогч талууд, тэдгээрийн холбогдох хэрэгцээ, хүлээлт болон мөрдөх шаардлагыг тодорхойлж, хянаж ажиллана.
Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлохдоо хууль тогтоомж, гэрээний шаардлага, байгууллагын стратегийн зорилт, санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгаа, холбогдох нэгжүүдийн мэдээллийг харгалзан үзнэ.

4.2.1. МУИС-ийн сонирхогч талууд

МУИС-ийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг, эсвэл үйл ажиллагаа, шийдвэрийн үр дүнд нөлөөлөлд өртөж болох хувь хүн, бүлэг, байгууллагыг сонирхогч тал гэж үзэж, дараах байдлаар ангилна.

А. Дотоод сонирхогч талууд

- Дээд удирдлага
- Багш, судлаачид
- Захиргааны болон үйлчилгээний ажилтнууд
- Суралцагчид
- Оюутны холбоо, клуб
- Үйлдвэрчний эвлэл

Б. Гадаад сонирхогч талууд

- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллага
- Хамтын ажиллагаатай дотоод, гадаадын их, дээд сургууль, судалгааны байгууллагууд
- Бусад боловсролын байгууллага
- Гаднын үйлчилгээ нийлүүлэгчид
- Хэвлэл, мэдээллийн байгууллагууд
- Магадлан итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллагууд
- Ажил олгогчид
- Зөвлөх, гэрээт болон цагийн багш нар
- Ахмад багш, ажилтны холбоо
- Төгсөгчид, төгсөгчдийн холбоо
- Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчид
- Нийгэм, олон нийт

4.2.2. МУИС-ийн сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт

МУИС-ийн нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах сонирхогч талуудын үндсэн хэрэгцээ, хүлээлтийг дараах байдлаар тодорхойлно.

Сонирхогч талууд	Үндсэн хэрэгцээ, хүлээлт
Дээд удирдлага	Стратегийн зорилтын хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэл, санхүүгийн тогтвортой байдал, хууль тогтоомж болон стандартын шаардлагын хэрэгжилт, шийдвэр гаргахад шаардлагатай бодит мэдээлэл
Багш, судлаачид	Аюулгүй, тохиромжтой ажиллах орчин, шаардлагатай тоног төхөөрөмж, шударга үнэлгээ, цалин урамшуулал, мэргэжлийн хөгжил, судалгааны дэмжлэг, академик эрх чөлөө
Ажилтнууд	Ажиллах орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, цалин урамшуулал, мэргэжлийн хөгжлийн боломж, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн эрхийн хэрэгжилт

Суралцагчид	Чанартай, хүртээмжтэй боловсрол, тодорхой сургалтын үр дүн, шударга үнэлгээ, аюулгүй сургалтын орчин, мэдээллийн хүртээмж, зөвлөгөө, дэмжлэг, тэтгэлэгт хамрагдах боломж
Оюутны холбоо, клуб	Суралцагчдын эрх ашиг, оролцоог хангах, үйл ажиллагаа явуулах боломж, сургуулийн удирдлагатай хамтран ажиллах
Үйлдвэрчний эвлэл	Гишүүдийн хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хамтын хэлэлцээрийн хэрэгжилт, мэдээлэл солилцоо
Төрийн захиргааны байгууллагууд	Хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын шаардлагын хэрэгжилт, тайлагнал, боловсролын чанар, ил тод байдал
Хамтын ажиллагаатай их, дээд сургууль, судалгааны байгууллагууд	Гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт, харилцан ашигтай хамтын ажиллагаа, хамтарсан сургалт, судалгаа, мэдээлэл солилцоо
Бусад боловсролын байгууллага	Шударга өрсөлдөөн, мэргэжлийн хамтын ажиллагаа, сайн туршлага солилцох боломж
Гаднын үйлчилгээ нийлүүлэгчид	Худалдан авах ажиллагааны ил тод, шударга нөхцөл, гэрээний тодорхой шаардлага, төлбөр тооцоог хугацаанд нь гүйцэтгэх
Хэвлэл, мэдээллийн байгууллагууд	Үнэн зөв, цаг үеийн, нийтэд нээлттэй мэдээлэл авах, албан ёсны эх сурвалжтай харилцах
Магадлан итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллагууд	Холбогдох стандарт, шалгуурын хэрэгжилт, үнэн зөв нотлох баримт, үнэлгээний үйл ажиллагаанд хамтран ажиллах, сайжруулалтын хэрэгжилт
Ажил олгогчид	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа болон багаар ажиллах чадвартай төгсөгчид, сургалтын хөтөлбөрт санал өгөх боломж
Зөвлөх, гэрээт, цагийн багш нар	Гэрээний тодорхой нөхцөл, үүрэг хариуцлагын ойлгомжтой байдал, шаардлагатай мэдээлэл, сургалтын орчин, төлбөрийн хугацааны хэрэгжилт
Ахмад багш, ажилтны холбоо	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах, туршлага, мэдлэгээ хуваалцах, хамтын ажиллагаанд оролцох
Төгсөгчид, төгсөгчдийн холбоо	Сургуультай тогтвортой харилцах, мэргэжлийн хөгжлийн боломж, хамтын ажиллагаа, сургуулийн хөгжилд хувь нэмэр оруулах
Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчид	Чанартай боловсрол, аюулгүй сургалтын орчин, холбогдох мэдээллийн хүртээмж, шаардлагатай тохиолдолд зөвлөгөө, дэмжлэг авах
Нийгэм, олон нийт	Чанартай боловсрол, судалгаа, инновац, нийгмийн хариуцлага, мэдлэг түгээх үйл ажиллагаа, ил тод байдал

4.2.3. Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийн хяналт

МУИС нь сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт болон тэдгээрт гарсан өөрчлөлтийг санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгаа, гэрээний хэрэгжилт, холбогдох нэгжүүдийн тайлан, дотоод аудит болон бусад мэдээллийн эх сурвалжид үндэслэн хянаж, үнэлнэ.

Нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах хэрэгцээ, хүлээлт, тэдгээрийн өөрчлөлтийг жилд нэгээс доошгүй удаа удирдлагын дүн шинжилгээний хурлаар авч үзэж, шаардлагатай

тохиолдолд холбогдох үйл ажиллагаа, эрсдэл ба боломжийн үнэлгээ, сайжруулалтын арга хэмжээнд тусгана.

Холбогдох баримт бичиг:

Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт – NUM/EOMS/FMT/15

4.3 Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох

МУИС нь ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагын дагуу нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлохдоо байгууллагын гадаад, дотоод асуудал, сонирхогч талуудын холбогдох хэрэгцээ, хүлээлт, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үзүүлж буй боловсролын үйлчилгээ болон холбогдох хууль тогтоомж, бусад шаардлагыг харгалзан үзнэ.
Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээнд МУИС-ийн баталгаажуулалтад хамрагдах захиргааны нэгж, бүрэлдэхүүн сургууль, холбогдох бусад нэгж, тэдгээрийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, нийгэмд чиглэсэн болон дэмжих үйл ажиллагаа хамаарна.
Хамрах хүрээнд хамаарах нэгж, байгууламжийн байршил, үйл ажиллагааны чиглэл, стандартын шаардлагын хэрэглэгдэх байдлыг тусдаа батлагдсан “МУИС-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээ” баримт бичигт тодорхойлсон бөгөөд уг баримт бичгийг нэгдсэн менежментийн тогтолцооны баримтжуулсан мэдээллийн нэг хэсэг болгон хянаж, шинэчилнэ.
Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, байршил болон холбогдох шаардлагад өөрчлөлт орсон тохиолдолд хамрах хүрээнд үзүүлэх нөлөөг үнэлж, шаардлагатай өөрчлөлтийг холбогдох журмын дагуу тусгана.

Холбогдох баримт бичиг:
МУИС-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээ – Хувилбар 02.

4.4 Нэгдсэн менежментийн тогтолцоо ба түүний үйл явц

МУИС нь ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагад нийцүүлэн нэгдсэн менежментийн тогтолцоог (НМТ) бий болгож, хэрэгжүүлэн, хэвийн ажиллагааг хангаж, тасралтгүй сайжруулна.
МУИС нь НМТ-д шаардлагатай үйл явцууд, тэдгээрийн дараалал, харилцан үйлчлэлийг тодорхойлж, байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ. Үйл явцуудыг стратегийн менежмент, сургалт, судалгаа, дэмжих үйл ажиллагаа гэсэн үндсэн бүлэгт ангилна.
Үйл явцын удирдлагын хүрээнд:

1. Үйл явц бүрийн шаардлагатай орц, хүлээгдэж буй гарц, дараалал, харилцан үйлчлэлийг тодорхойлно.
2. Үйл явцын үр нөлөөтэй ажиллагаа, хяналтыг хангах шалгуур, арга, гүйцэтгэлийн үзүүлэлт, шаардлагатай хэмжилт, мониторингийг тогтооно.
3. Үйл явцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, дэд бүтэц, мэдээлэл, санхүүгийн болон бусад нөөцийг тодорхойлж, боломжит хүрээнд хангана.
4. Үйл явцын хариуцагч, оролцогч нэгжүүдийн үүрэг, эрх мэдэл, хариуцлагыг тодорхойлж, холбогдох ажилтнуудад мэдээлнэ.
5. Үйл явцтай холбоотой эрсдэл, боломжийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.
6. Үйл явцын гүйцэтгэл, үр нөлөөг мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээгээр хянаж, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй тохиолдолд шаардлагатай залруулга, сайжруулалтын арга хэмжээ авна.
7. Үйл явцын хэрэгжилтийг дэмжих, төлөвлөсний дагуу хэрэгжсэнийг нотлох шаардлагатай баримтжуулсан мэдээллийг боловсруулж, хөтөлж, хадгална.

Үндсэн үйл явцууд болон хариуцсан нэгжүүд

Үйл явцын бүлэг	Хариуцсан болон оролцогч нэгжүүд
Стратегийн менежмент	Ректор, Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл болон холбогдох захиргааны нэгжүүд
Сургалт (боловсролын үйлчилгээ)	Сургалт, хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын газар, Оюутны хөгжлийн газар, Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төв, бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд
Судалгаа	Судалгаа, хөгжүүлэлтийн газар, бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд, судалгааны хүрээлэн, төвүүд
Дэмжих үйл ажиллагаа	Захиргаа, хүний нөөцийн газар, Санхүү, бүртгэлийн газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Цахим шилжилтийн газар, Номын сан, Хангамж, үйлчилгээний газар болон холбогдох бусад нэгжүүд

Үйл явцуудын дараалал, харилцан үйлчлэлийг “НМТ-ийн үйл явцын дараалал ба харилцан үйлчлэлийн график” (Хавсралт II)-т тусгасан бөгөөд холбогдох журам, заавар, бүртгэлээр үйл явцын хэрэгжилтийг зохицуулна.

Холбогдох баримт бичиг:

- НМТ-ийн үйл явцын дараалал ба харилцан үйлчлэлийн график – Хавсралт II
- Баримт бичгийн мастер (үндсэн) жагсаалт – NUM/EOMS/FMT/09
- Бүртгэлийн мастер (үндсэн) жагсаалт – NUM/EOMS/FMT/11

БҮЛЭГ 5: МАНЛАЙЛАЛ

5.1 Манлайлал ба амлалт

5.1.1 Ерөнхий зүйл

МУИС-ийн дээд удирдлага нь ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагад нийцүүлэн нэгдсэн менежментийн тогтолцоог (НМТ) хэрэгжүүлэх, үр нөлөөг хангах, тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд манлайлал, амлалтаа дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. НМТ-ийн үр нөлөө, гүйцэтгэлийн төлөө хариуцлага хүлээж, хэрэгжилтийг удирдан зохион байгуулна.
2. НМТ-ийн бодлого, зорилтыг МУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, стратегийн чиглэл болон байгууллагын төлөв байдалтай уялдуулан тогтооно.
3. НМТ-ийн шаардлагыг байгууллагын үндсэн болон дэмжих үйл явц, өдөр тутмын удирдлага, төлөвлөлт, шийдвэр гаргалтад нэгтгэн хэрэгжүүлнэ.
4. Үйл явцын хандлага, эрсдэлд суурилсан сэтгэлгээг дэмжиж, эрсдэл ба боломжийг удирдлагын шийдвэрт харгалзан үзнэ.
5. НМТ-ийн хэрэгжилтэд шаардлагатай хүний нөөц, санхүү, дэд бүтэц, технологи, мэдээлэл болон бусад нөөцийн хэрэгцээг тодорхойлж, зохих шийдвэр гаргана.
6. НМТ-ийн шаардлагыг биелүүлэх, үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн ач холбогдлыг багш, ажилтан болон холбогдох сонирхогч талуудад таниулж, оролцоог дэмжинэ.
7. НМТ-ийн зорьсон үр дүнд хүрч байгаа эсэхийг гүйцэтгэлийн үнэлгээ, хяналт-шинжилгээ, дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээгээр хянаж, шаардлагатай шийдвэр гаргана.
8. НМТ-ийн үр нөлөөг сайжруулахад багш, ажилтнуудын оролцоо, санаачилгыг дэмжиж, холбогдох удирдлагын албан тушаалтнуудын манлайллыг хөгжүүлнэ.
9. Суралцагч болон бусад үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, хүлээлт, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг хангахад анхаарч ажиллана.
10. Суралцагчдын суралцах үйл ажиллагаа, сургалтын үр дүн, хүртээмж, тэгш боломж, нийгмийн хариуцлагыг байгууллагын удирдлага, төлөвлөлтөд харгалзан үзнэ.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа
- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2025–2030
- МУИС-ийн дүрэм
- Удирдах зөвлөлийн дүрэм
- Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам
- НМТ-ийн бодлого, зорилт
- Удирдлагын дүн шинжилгээний хурлын тэмдэглэл, шийдвэр

5.1.2 Суралцагч болон бусад үйлчлүүлэгчдэд төвлөрөх

МУИС-ийн дээд удирдлага нь суралцагч болон бусад үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, сургалтын үр дүн болон сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.

Энэ хүрээнд:

1. Суралцагч болон бусад үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, хүлээлт, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг тодорхойлж, хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2. Сургалтын хөтөлбөр, боловсролын үйлчилгээний чанар, суралцахуйн үр дүнд нөлөөлөх эрсдэл, боломжийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг авна.
3. Суралцагчдын санал хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, шийдвэрлэж, үр дүнд нь дүн шинжилгээ хийнэ.

4. Суралцагч болон бусад үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, хэрэгцээ, хүлээлтийн өөрчлөлтийг судалгаа, санал хүсэлт, гүйцэтгэлийн мэдээллээр хянаж, сайжруулалтад ашиглана.
5. Суралцагчдын оролцоо, тэгш боломж, хүртээмжтэй суралцах орчныг дэмжиж, боловсролын үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.

5.1.3 Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС-ийн дээд удирдлага нь тусгай хэрэгцээт суралцагчдын боловсрол эзэмших тэгш боломж, хүртээмж, оролцоог дэмжихэд анхаарч, холбогдох хууль тогтоомж болон ISO 21001:2018 стандартын шаардлагыг харгалзан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Тусгай хэрэгцээт суралцагчдын хэрэгцээ, хүсэлт, санал мэдээллийг хүлээн авах, холбогдох нэгжид уламжлах, шийдвэрлэх боломжтой харилцаа холбооны арга хэлбэрийг тодорхойлж, мэдээллийн хүртээмжийг дэмжинэ.
2. Суралцагчийн хэрэгцээ, сургалтын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн суралцах орчин, сургалтын материал, мэдээлэл, үнэлгээний арга хэлбэрт шаардлагатай бөгөөд боломжит тохируулга хийх асуудлыг холбогдох нэгжүүдтэй хамтран шийдвэрлэнэ.
3. Сургалтын орчин, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжид тулгарч буй хүндрэл, саадыг тодорхойлж, сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
4. Тусгай хэрэгцээт суралцагчдын хувийн мэдээллийн нууцлал, нэр төр, бие даасан байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчмыг баримтална.
5. Хүртээмж, дэмжлэгтэй холбоотой санал хүсэлт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, сайжруулалтын хэрэгцээг холбогдох үйл ажиллагааны үнэлгээнд тусгана.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн суралцагчдад дэмжлэг үзүүлэх холбогдох бодлого, журам
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан үйлчилгээний холбогдох баримт бичиг
- Суралцагчдын санал хүсэлт, өргөдөл, гомдлын бүртгэл
- Сургалтын орчин, хүртээмжийн үнэлгээ, сайжруулалтын холбогдох мэдээлэл

5.2 Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого

5.2.1. Бодлого боловсруулах

МУИС-ийн дээд удирдлага нь байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратегийн чиглэл, үйл ажиллагааны онцлогт нийцсэн, ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагыг хангасан Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлж, тогтмол хянан үзнэ.

НМТ-ийн бодлого нь:

1. Байгууллагын зорилго, төлөв байдал, стратегийн чиглэлтэй нийцсэн байна.
2. НМТ-ийн зорилтуудыг тодорхойлох үндэс суурийг бүрдүүлнэ.
3. Холбогдох хууль тогтоомж, зохицуулалт болон бусад хэрэглэх шаардлагыг хангах амлалтыг тусгана.
4. Суралцагч болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг харгалзан үзнэ.
5. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш боломж, суралцахуйн үр дүнг дэмжинэ.
6. Багш, ажилтнуудын оролцоо, мэргэжлийн хөгжил, байгууллагын нийгмийн хариуцлагыг дэмжинэ.
7. Нэгдсэн менежментийн тогтолцооны үр нөлөө, тасралтгүй сайжруулалтын амлалтыг агуулна.

5.2.2. Бодлогыг мэдээлэх

МУИС нь НМТ-ийн бодлогыг батлагдсан баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр хадгалж, байгууллагын хэмжээнд мэдээлэн, багш, ажилтнуудад ойлгуулж, холбогдох үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ.

Бодлогыг МУИС-ийн албан ёсны цахим хуудас, нэгдсэн менежментийн тогтолцооны цахим мэдээллийн хэсэг, байгууллагын дотоод мэдээллийн сувгууд болон шаардлагатай бусад хэлбэрээр түгээж, холбогдох сонирхогч талуудад хүртээмжтэй байлгана.
Бодлогын хэрэгжилт, нийцтэй байдлыг удирдлагын дүн шинжилгээний хүрээнд хянан үзэж, шаардлагатай тохиолдолд шинэчилнэ.

Холбогдох баримт бичиг:
МУИС-ийн Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого (Хавсралт III).

5.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл

МУИС нь батлагдсан зохион байгуулалтын бүтцийн дагуу удирдлага, захиргаа, бүрэлдэхүүн болон салбар сургууль, сургалт, судалгаа, үйлчилгээний болон бусад холбогдох нэгжүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.
МУИС-ийн дээд удирдлага нь нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) хэрэгжилттэй холбоотой үүрэг, хариуцлага, эрх мэдлийг холбогдох нэгж, албан тушаалтанд тодорхой хуваарилж, байгууллагын дүрэм, бүтцийн шийдвэр, албан тушаалын тодорхойлолт, тушаал, журам болон бусад холбогдох баримт бичгээр баталгаажуулж, мэдээлнэ.
НМТ-ийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэх хариуцлага, эрх мэдлийг холбогдох нэгж, албан тушаалтанд хуваарилна. Үүнд:

1. НМТ нь ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын холбогдох шаардлагад нийцэж байгааг хангах.
2. НМТ-ийн бодлого, зорилтыг байгууллагын хэмжээнд мэдээлж, ойлгуулан, хэрэгжилтийг дэмжих.
3. НМТ-ийн үйл явцууд төлөвлөсөн үр дүнд хүрч байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.
4. НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөө, сайжруулах боломж болон шаардлагатай арга хэмжээний талаар дээд удирдлагад тайлагнах.
5. Байгууллагын хэмжээнд суралцагч болон бусад үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, хүлээлтэд төвлөрсөн хандлагыг дэмжих.
6. НМТ-д өөрчлөлт төлөвлөж, хэрэгжүүлэх явцад тогтолцооны уялдаа холбоо, бүрэн бүтэн байдлыг хадгалах.
7. НМТ-тэй холбоотой дотоод, гадаад харилцаа холбоо, мэдээлэл солилцоог зохион байгуулах.
8. Сургалтын хэлбэр, зохион байгуулалтаас үл хамааран боловсролын үйлчилгээний үйл явцуудын уялдаа, нэгдмэл байдлыг хангах.
9. НМТ-ийн баримтжуулсан мэдээллийн боловсруулалт, баталгаажуулалт, хадгалалт, өөрчлөлтийн хяналтыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлэх.
10. Тусгай хэрэгцээт суралцагчдын хэрэгцээ, хүртээмж, дэмжлэгтэй холбоотой шаардлагын хэрэгжилтийг холбогдох нэгжүүдийн чиг үүрэгт тусгаж, зохицуулах.

НМТ-ийн хэрэгжилтэд оролцогч нэгж, албан тушаалтнууд нь өөрийн чиг үүргийн хүрээнд холбогдох шаардлагыг хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүн болон сайжруулах шаардлагатай асуудлыг тогтоосон удирдлага, тайлагналын сувгаар мэдээлнэ.
Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн зохион байгуулалтын бүтцийн диаграмм (Хавсралт IV)
- Албан тушаалын тодорхойлолтууд
- Үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хуваарилалттай холбоотой тогтоол, тушаал, шийдвэр
- МУИС-ийн хүний нөөц, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой холбогдох журам
- МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн холбогдох дүрэм
- МУИС-ийн сургалт, судалгаа, үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулсан холбогдох журам
- Зөвшөөрлийн мэдэгдэл (Хавсралт V)

БҮЛЭГ 6. ТӨЛӨВЛӨЛТ

6.1. Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээ

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) төлөвлөлтийн хүрээнд байгууллагын гадаад, дотоод асуудал, сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт болон холбогдох шаардлагыг харгалзан эрсдэл, боломжийг тодорхойлж, үнэлж, удирдана.

Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээ нь:

1. НМТ-ийг төлөвлөсөн үр дүнд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;
2. Эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх, боломжийг ашиглах;
3. Болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, бууруулах;
4. Үйл ажиллагаа, боловсролын үйлчилгээ болон НМТ-ийн үр нөлөөг тасралтгүй сайжруулахад чиглэнэ.

Эрсдэл ба боломжийг байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны түвшинд, холбогдох үйл явцын онцлогт нийцүүлэн тодорхойлж, “Эрсдэл ба боломжийн менежментийн журам” (NUM/EOMS/PRO/007)-ын дагуу үнэлж, бүртгэнэ.

Эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлийг бууруулах, хянах, шаардлагатай тохиолдолд сэргийлэх арга хэмжээг, боломжийн хувьд ашиглах, хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ. Арга хэмжээний цар хүрээ нь тухайн эрсдэл, боломжийн боловсролын үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүн болон НМТ-д үзүүлэх боломжит нөлөөлөлтэй нийцсэн байна.

Төлөвлөсөн арга хэмжээг холбогдох үйл явц, нэгжийн үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжилт болон үр нөлөөг хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд хянана.

Эрсдэл ба боломжийн бүртгэлийг жилд нэгээс доошгүй удаа, мөн байгууллагын нөхцөл байдал, үйл ажиллагаа, хууль тогтоомж болон бусад шаардлагад томоохон өөрчлөлт орсон тохиолдолд шаардлагатай хэмжээнд хянан үзэж, шинэчилнэ.

Холбогдох баримт бичиг:

- Эрсдэл ба боломжийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/007)
- Эрсдэлийн үнэлгээний бүртгэл
- Эрсдэлийг бууруулах болон боломжийг ашиглах арга хэмжээний төлөвлөгөө

6.2. Нэгдсэн менежментийн тогтолцооны зорилт, түүнд хүрэх төлөвлөлт

МУИС нь НМТ-ийн бодлого, байгууллагын стратегийн төлөвлөгөө болон холбогдох шаардлагад нийцүүлэн менежментийн тогтолцооны зорилтуудыг байгууллагын холбогдох чиг үүрэг, түвшин, үйл явцад тодорхойлж, хэрэгжилтийг төлөвлөнө.

НМТ-ийн зорилтууд нь:

1. НМТ-ийн бодлоготой нийцсэн;
2. Боломжтой хэмжээнд хэмжигдэхүйц, үнэлэх шалгуур үзүүлэлттэй;
3. Холбогдох хууль тогтоомж, стандарт болон бусад шаардлагыг харгалзсан;
4. Боловсролын үйлчилгээний чанар, суралцахуйн үр дүн, суралцагч болон бусад үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн;
5. Хэрэгжилтийг нь хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хянах боломжтой;
6. Холбогдох нэгж, ажилтнуудад мэдээлэгдсэн;
7. Шаардлагатай тохиолдолд шинэчлэгдэх боломжтой байна.

НМТ-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Шаардлагатай нөөц, эх үүсвэр;
- Хариуцах нэгж, албан тушаалтан;
- Хэрэгжүүлэх хугацаа;
- Хүрэх үр дүн, хэмжих үзүүлэлт;
- Үр дүнг үнэлэх арга, шалгуур.

НМТ-ийн зорилтуудын хэрэгжилтийг байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулан хянана.
Холбогдох нэгжүүд зорилтын хэрэгжилт, гүйцэтгэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай сайжруулалтын арга хэмжээг тодорхойлно. НМТ-ийн зорилтуудын хэрэгжилт, үр дүнг удирдлагын дүн шинжилгээний хурлаар хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргана.

Холбогдох баримт бичиг:
- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2025–2030
- НМТ-ийн бодлого
- НМТ-ийн зорилтуудын төлөвлөгөө (Хавсралт XXXIV)
- Холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан

6.3. Өөрчлөлтийг төлөвлөх

МУИС нь НМТ-д өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүссэн тохиолдолд өөрчлөлтийг төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай хэрэгжүүлнэ.
НМТ-д хамаарах өөрчлөлтийг “Өөрчлөлтийн менежментийн журам” (NUM/EOMS/PRO/006)-ын дагуу төлөвлөж, хэрэгжүүлэхдээ дараах асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Өөрчлөлтийн зорилго, үндэслэл болон болзошгүй үр дагавар;
2. НМТ-ийн үйл явцуудын уялдаа холбоо, бүрэн бүтэн байдалд үзүүлэх нөлөөлөл;
3. Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, мэдээлэл, дэд бүтэц болон бусад нөөцийн боломж, бэлэн байдал;
4. Холбогдох нэгж, албан тушаалтны үүрэг, хариуцлага, эрх мэдлийг хуваарилах буюу дахин хуваарилах хэрэгцээ;
5. Шаардлагатай тохиолдолд гаднын үйлчилгээ үзүүлэгч болон бусад сонирхогч талуудын оролцоо, бэлэн байдал;
6. Өөрчлөлтөөс үүсэж болзошгүй эрсдэл, боломж болон тэдгээрт чиглэсэн арга хэмжээ.

Өөрчлөлтийг холбогдох журмын дагуу төлөвлөж, хэрэгжүүлсний дараа үр дүн, үйл явцын ажиллагаа болон НМТ-ийн шаардлагад үзүүлсэн нөлөөллийг хянан үнэлж, шаардлагатай залруулга, сайжруулалтын арга хэмжээг авна.
Өөрчлөлттэй холбоотой шийдвэр, төлөвлөгөө, хэрэгжилт, үнэлгээний мэдээллийг холбогдох шаардлагын дагуу баримтжуулна.

Холбогдох баримт бичиг:
- Өөрчлөлтийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/006)

БҮЛЭГ 7. ТУЛГУУР ХҮЧИН ЗҮЙЛ

7.1. Нөөц

7.1.1. Ерөнхий зүйл

МУИС нь ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардлагад нийцүүлэн нэгдсэн менежментийн тогтолцоог (НМТ) бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах, тасралтгүй сайжруулахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, төлөвлөж, хуваарилан, ашиглалтад нь хяналт тавина.

Нөөцийн хэрэгцээг тодорхойлохдоо байгууллагын стратегийн зорилт, сургалт, судалгаа, үйлчилгээний үйл ажиллагааны онцлог, суралцагч болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, үйл явцын эрсдэл, боломж, дотоод нөөцийн чадавх, хязгаарлалт болон гаднын эх үүсвэрээс хангах боломжийг харгалзан үзнэ. НМТ-ийн хэрэгжилтэд шаардлагатай нөөцөд дараах зүйлс хамаарна. Үүнд:

1. **Хүний нөөц:** Багш, судлаач, захиргааны болон үйлчилгээний ажилтан, гэрээт болон бусад холбогдох мэргэжилтэн.
2. **Санхүүгийн нөөц:** Байгууллагын батлагдсан төсөв, өөрийн орлого, төсөл, хөтөлбөр, гэрээт ажил болон хууль тогтоомжид нийцсэн бусад санхүүжилтийн эх үүсвэр.
3. **Дэд бүтэц:** Барилга байгууламж, сургалтын танхим, лаборатори, тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн дэд бүтэц, номын сан болон бусад шаардлагатай орчин.
4. **Технологи, мэдээллийн нөөц:** Программ хангамж, мэдээллийн систем, сургалтын цахим платформ, мэдээллийн сан болон холбогдох техник, технологи.
5. **Байгууллагын мэдлэг:** Багш, ажилтнуудын мэдлэг, ур чадвар, туршлага, судалгааны үр дүн, сургалтын болон үйл ажиллагааны баримтжуулсан мэдээлэл.
6. **Гаднаас хангах нөөц, үйлчилгээ:** Гэрээт ажилтан, зочин багш, судлаач, зөвлөх үйлчилгээ, бараа материал, тоног төхөөрөмж, инженерийн хангамж болон бусад шаардлагатай үйлчилгээ.

МУИС нь нөөцийг төлөвлөх, хуваарилах, ашиглахдаа суралцагчдын суралцах үйл ажиллагаа, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, багш, ажилтнуудын ажлын нөхцөл, чадамж, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг харгалзан үзнэ.Тусгай хэрэгцээт суралцагчдын хэрэгцээ, суралцах орчны хүртээмжийг нөөцийн төлөвлөлтөд тусгаж, шаардлагатай тохируулга, дэмжлэг үзүүлэх боломжийг холбогдох нэгжүүдтэй хамтран тодорхойлно.

Нөөцийн хүрэлцээ, ашиглалт, үр нөлөө болон сайжруулах хэрэгцээг байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, удирдлагын дүн шинжилгээний хүрээнд хянан үзэж, шаардлагатай шийдвэр гаргана.

7.1.2. Хүний нөөц

МУИС нь эрхэм зорилго, алсын хараа, стратегийн зорилт болон НМТ-ийн шаардлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрэм, хүний нөөцийн бодлого, журмын дагуу бүрдүүлж, хөгжүүлж, удирдана.

Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, томилгоо, ажил үүргийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээ болон хөгжлийн үйл ажиллагааг “Хүний нөөцийн үйл явцын гарын авлага” (NUM/EOMS/PFC/009) болон холбогдох журмаар зохицуулна.

НМТ-ийн үйл явцуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг дараах үндсэн хэлбэрээр бүрдүүлнэ. Үүнд:

1. **Үндсэн багш, ажилтан:** Сургалт, судалгаа, удирдлага, захиргаа, үйлчилгээ болон бусад үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтнууд. Албан тушаалд тавигдах шаардлага, чиг үүрэг, хариуцлагыг холбогдох албан тушаалын тодорхойлолт, журмаар тогтооно.
2. **Гэрээт болон зочин багш, судлаач, мэргэжилтэн:** Сургалт, судалгаа болон бусад үйл ажиллагааны хэрэгцээнд үндэслэн холбогдох журмын дагуу гэрээгээр ажиллах ажилтнууд.

3. **Туслах болон цагийн ажил гүйцэтгэгч:** Магистрант, докторант, оюутан болон бусад холбогдох этгээдийг хууль тогтоомж, байгууллагын журмын дагуу сургалт, судалгаа, дэмжих үйл ажиллагаанд оролцуулах боломжтой.

МУИС нь хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлохдоо үйл ажиллагааны ачаалал, ажилтны чадамж, ажлын байрны шаардлага, сургалт, судалгааны онцлог, үйлчилгээний чанар болон НМТ-ийн үйл явцын хэрэгцээг харгалзан үзнэ.

Багш, ажилтнуудын шаардлагатай чадамж, мэргэжлийн хөгжил, сургалтын хэрэгцээ, гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг холбогдох журам болон энэхүү гарын авлагын 7.2. Чадамж хэсэгт тусгана.

Хүний нөөцийн тоо, бүрэлдэхүүн, хөдөлгөөн, гэрээт ажилтны мэдээлэл болон холбогдох үзүүлэлтүүдийг байгууллагын хүний нөөцийн бүртгэл, тайлангаар баримтжуулна.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн зохион байгуулалтын бүтцийн диаграмм (Хавсралт IV)
- Хүний нөөцийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/009, Хавсралт VIII)
- МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- МУИС-д ажилтан ажиллуулах холбогдох журам
- МУИС-д профессор багш ажиллуулах болон гэрээт, зочин багш, судлаач ажиллуулах холбогдох журам
- Эрдэм шинжилгээний ажилтан, постдоктор, магистрант, докторантыг туслахаар ажиллуулах холбогдох журам
- Багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ, мэргэжлийн хөгжлийг зохицуулсан холбогдох журам

7.1.3. Дэд бүтэц

МУИС нь сургалт, судалгаа, нийгэмд чиглэсэн болон дэмжих үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх, боловсролын үйлчилгээний шаардлагыг хангахад шаардлагатай дэд бүтцийг тодорхойлж, бүрдүүлж, ашиглалт, засвар үйлчилгээ, сайжруулалтыг зохион байгуулна.

Дэд бүтцийн хэрэгцээ, хөгжүүлэлтийг МУИС-ийн 2025–2030 оны стратегийн төлөвлөгөөний **“Сурах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх”** зорилт болон холбогдох үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ. МУИС-ийн үйл ажиллагаанд ашиглах дэд бүтцэд дараах зүйлс хамаарна. Үүнд:

1. Сургалт, судалгаа, захиргаа, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, анги танхим;
2. Судалгааны лаборатори, сургалт, дадлагын бааз, тоног төхөөрөмж;
3. Номын сан, сургалтын материал, мэдээллийн нөөц;
4. Мэдээллийн технологийн техник, программ хангамж, сүлжээ, цахим сургалтын систем;
5. Оюутны дотуур байр болон суралцагчдад зориулсан бусад байгууламж;
6. Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, цахилгаан, дулаан, усан хангамж, агааржуулалт болон бусад шаардлагатай дэд бүтэц.

Дэд бүтцийн ашиглалт, бүртгэл, хадгалалт, засвар үйлчилгээ, шинэчлэл, аюулгүй ажиллагааг холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрэм, журам, үйл явцын зохицуулалтын дагуу хариуцсан нэгжүүд хэрэгжүүлнэ.

Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын нөхцөл, техникийн байдал, насжилт, засвар үйлчилгээний хэрэгцээ болон эрсдэлийг холбогдох үнэлгээ, үзлэг, бүртгэлд үндэслэн тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөнө.

Дэд бүтцийн хүрэлцээ, ашиглалтын байдал, сайжруулах хэрэгцээг байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ болон удирдлагын дүн шинжилгээний хүрээнд харгалзан үзнэ.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2025–2030
- МУИС-ийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам
- МУИС-ийн оюутны дотуур байрны журам
- МУИС-ийн номын сангийн журам
- Судалгааны лаборатори ажиллуулах холбогдох журам
- Аж ахуй, эд хөрөнгийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/007, Хавсралт XV)
- Мэдээллийн технологийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/010, Хавсралт XVII)
- Кампусын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/005, Хавсралт XIII)

7.1.4. Үйл явцыг хэрэгжүүлэх орчин

МУИС нь сургалт, судалгаа, үйлчилгээний үйл явцыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай, суралцагч, багш, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, оролцоо, суралцах болон ажиллах нөхцөлийг дэмжсэн орчныг бүрдүүлэх, хадгалах, сайжруулахад анхаарч ажиллана. Үйл явцыг хэрэгжүүлэх орчныг дараах үндсэн чиглэлээр зохицуулна. Үүнд:

1. **Физик орчин:** Сургалтын танхим, лаборатори, ажлын байрны гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан, дуу чимээ, ариун цэвэр, эрүүл ахуй болон аюулгүй байдлын шаардлагыг хангах.
2. **Суралцах орчин:** Суралцагчдын сургалтын үйл ажиллагаанд оролцох, мэдээлэл, сургалтын материал, номын сан, цахим үйлчилгээ болон холбогдох дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлэх.
3. **Нийгэм, сэтгэл зүйн орчин:** Суралцагч, багш, ажилтнуудын харилцан хүндэтгэл, ёс зүй, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчим, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих.
4. **Хүртээмжтэй орчин:** Тусгай хэрэгцээт суралцагчдын хэрэгцээ, боломжийг харгалзан сургалтын орчин, мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.
5. **Цахим орчин:** Цахим сургалт, мэдээлэл солилцоо, сургалтын удирдлагын системийн ашиглалт, мэдээллийн аюулгүй байдал болон хүртээмжийг дэмжих.

Сургалт, судалгааны орчны шаардлагад нийцсэн байдлыг холбогдох нэгжүүд өөрийн чиг үүргийн хүрээнд хянаж, илэрсэн хүндрэл, эрсдэл, сайжруулах шаардлагатай асуудлыг холбогдох удирдлагад мэдээлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

МУИС нь суралцагчдын сэтгэл зүйн эрүүл мэнд, дасан зохицол, суралцах үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэлтэй холбоотой дэмжлэг үзүүлэх үйлчилгээг холбогдох журам, зохицуулалтын дагуу хэрэгжүүлнэ.

Багш, ажилтнуудын ажлын орчин, харилцаа, сэтгэл ханамж, мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг холбогдох судалгаа, үнэлгээ, санал хүсэлтээр тодорхойлж, хүний нөөцийн хөгжил болон ажлын орчны сайжруулалтад харгалзан үзнэ.

Үйл явцыг хэрэгжүүлэх орчны хүрэлцээ, тохиромжтой байдал, сайжруулах хэрэгцээг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт-шинжилгээ, удирдлагын дүн шинжилгээний хүрээнд үнэлнэ.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- МУИС-ийн сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын холбогдох журам
- МУИС-ийн номын сангийн журам
- МУИС-ийн оюутны дотуур байрны журам
- Суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам
- МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн холбогдох дүрэм
- МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр
- Багш, ажилтны хөгжлийг дэмжих холбогдох журам

7.1.5. Мониторинг, хэмжилтийн нөөц

7.1.5.1. Ерөнхий зүйл

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) үйл явцын гүйцэтгэл, боловсролын үйлчилгээний шаардлагад нийцсэн байдал болон үр дүнг үнэлэхэд шаардлагатай мониторинг, хэмжилтийн нөөцийг тодорхойлж, бүрдүүлж, ашиглана.
Мониторинг, хэмжилтийн нөөцөд сургалт, судалгаа, үйлчилгээний үйл ажиллагааны онцлогт нийцсэн үнэлгээний арга, шалгуур, шалгалт, тестийн хэрэгсэл, судалгааны аргачлал, программ хангамж, лабораторийн хэмжих хэрэгсэл болон бусад холбогдох тоног төхөөрөмж хамаарна.
МУИС нь мониторинг, хэмжилтийн үр дүнгийн хүчинтэй, найдвартай байдлыг хангах зорилгоор дараах шаардлагыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Ашиглаж буй нөөц нь тухайн мониторинг, хэмжилтийн зорилго, арга, үйл ажиллагааны онцлогт тохирсон байх;
2. Хэмжилт, үнэлгээг гүйцэтгэх ажилтан шаардлагатай чадамжтай байх;
3. Хэмжилт, үнэлгээний арга, хэрэгслийн тохиромжтой байдал, ашиглалтын нөхцөлийг хангах;
4. Шаардлагатай тохиолдолд хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт, техникийн үйлчилгээ хийх;
5. Мониторинг, хэмжилтийн нөөцийн тохиромжтой байдлыг нотлох шаардлагатай баримтжуулсан мэдээллийг хадгалах.

Мониторинг, хэмжилтийн нөөцийн хүрэлцээ, тохиромжтой байдал болон сайжруулах хэрэгцээг холбогдох нэгжүүд үйл ажиллагааны онцлог, эрсдэл, шаардлагад үндэслэн тодорхойлно.

7.1.5.2. Хэмжилтийн мөшгөх боломж

Хэмжилтийн мөшгөх боломж нь хууль тогтоомж, холбогдох стандарт, гэрээний шаардлагаар тогтоогдсон, эсхүл хэмжилтийн үр дүнгийн үнэн зөв, найдвартай байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд МУИС нь холбогдох хэмжих хэрэгсэлд дараах шаардлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хэмжих хэрэгслийг үндэсний болон олон улсын хэмжилтийн эталонд мөшгөх боломжтой эталоны дагуу тогтоосон давтамжаар, эсхүл ашиглахын өмнө шалгалт тохируулга, баталгаажуулалтад хамруулах;
2. Мөшгөх боломжтой хэмжилтийн эталон байхгүй тохиолдолд шалгалт тохируулга, баталгаажуулалтад ашигласан үндэслэлийг баримтжуулах;
3. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын төлөв байдлыг тодорхойлох;
4. Хэмжилтийн үр дүнд нөлөөлж болзошгүй гэмтэл, тохиргооны өөрчлөлт болон бусад сөрөг нөлөөллөөс хэмжих хэрэгслийг хамгаалах.

Хэмжих хэрэгсэл зориулалтын дагуу ашиглахад тохиромжгүй болох нь тогтоогдсон тохиолдолд өмнөх хэмжилтийн үр дүнд үзүүлсэн нөлөөллийг үнэлж, шаардлагатай залруулга болон бусад арга хэмжээг авна.
Шалгалт тохируулга, баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн төлөв байдал болон холбогдох арга хэмжээний баримтжуулсан мэдээллийг шаардлагын дагуу хадгална.

7.1.6. Байгууллагын мэдлэг

МУИС нь сургалт, судалгаа, нийгэмд чиглэсэн болон дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, боловсролын үйлчилгээний шаардлагыг хангах, байгууллагын хөгжлийг дэмжихэд шаардлагатай мэдлэгийг тодорхойлж, хадгалж, хуваалцаж, ашиглана.

Байгууллагын мэдлэг нь МУИС-ийн үйл ажиллагааны явцад бий болсон мэдлэг, туршлага, мэдээлэл, судалгааны үр дүн, оюуны бүтээл болон гаднын эх сурвалжаас олж авсан холбогдох мэдлэгээс бүрдэнэ.

Байгууллагын мэдлэгийн эх сурвалжийг дараах байдлаар ангилна.

Дотоод эх сурвалж:

- Байгууллагын бодлого, стратегийн төлөвлөгөө, дүрэм, журам, үйл явцын баримтжуулсан мэдээлэл;
- Сургалтын хөтөлбөр, хичээлийн материал, сурах бичиг, гарын авлага, үнэлгээний аргачлал;
- Эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны төсөл, тайлан, инновац, оюуны өмч;
- Багш, судлаач, ажилтнуудын мэдлэг, ур чадвар, хуримтлуулсан туршлага;
- Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, удирдлагын дүн шинжилгээний үр дүн;
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанаас олж авсан сургамж, сайн туршлага.

Гадаад эх сурвалж:

- Үндэсний болон олон улсын стандарт, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг;
- Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар, мэргэжлийн сургалт;
- Хамтарсан сургалт, судалгааны төсөл, хөтөлбөр;
- Дотоод, гадаадын их сургууль, судалгааны байгууллага, мэргэжлийн байгууллагатай хэрэгжүүлсэн хамтын ажиллагаа;
- Шинжлэх ухаан, технологи, боловсролын салбарын шинэ мэдлэг, судалгааны үр дүн, шилдэг туршлага.

МУИС нь байгууллагын мэдлэгийг холбогдох баримт бичиг, мэдээллийн сан, сургалт, судалгааны болон удирдлагын мэдээллийн систем, номын сан, цахим платформ, архив болон бусад тохиромжтой хэрэгслээр хадгалж, ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Байгууллагын мэдлэгийг түгээх, хуваалцах үйл ажиллагааг сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, мэргэжлийн хөгжлийн хөтөлбөр, туршлага солилцох арга хэмжээ болон дотоод мэдээлэл солилцооны сувгаар хэрэгжүүлнэ.

МУИС нь үйл ажиллагааны хэрэгцээ, өөрчлөгдөж буй нөхцөл байдал, шинэ технологи, мэдлэгийн шаардлагыг харгалзан байгууллагын мэдлэгийн хүрэлцээг үнэлж, шаардлагатай нэмэлт мэдлэгийг дотоод болон гадаад эх сурвалжаас олж авах, хөгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

Байгууллагын мэдлэгийг хадгалах, ашиглах, түгээхдээ оюуны өмч, зохиогчийн эрх, мэдээллийн нууцлал, хамгаалалт болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын журмыг мөрдөнө.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого
- МУИС-ийн технологи дамжуулах журам
- МУИС-ийн албан хэрэг хөтлөлтийн журам
- Хамтын ажиллагааны гэрээ байгуулах холбогдох журам
- Магистр, докторын судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх журам
- Сурах бичиг зохиох, орчуулах үйл ажиллагааг зохицуулах журам
- Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн хэвлүүлэхэд баримтлах журам

7.2. Чадамж

7.2.1. Ерөнхий зүйл

МУИС нь НМТ-ийн үйл явцын гүйцэтгэл, боловсролын үйлчилгээний чанар, ур нөлөөнд нөлөөлөх ажилтнуудын шаардлагатай чадамжийг тодорхойлж, тэдгээрийн боловсрол,

мэргэжил, сургалт, ур чадвар, туршлагад үндэслэн үнэлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
Чадамжийн шаардлагыг албан тушаалын тодорхойлолт, холбогдох хууль тогтоомж, мэргэжлийн болон байгууллагын шаардлагад нийцүүлэн тогтооно.
МУИС нь ажилтнуудын чадамжийг хангах, хөгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. НМТ-ийн үйл ажиллагаанд нөлөөлөх албан тушаал, ажил үүрэгт шаардагдах чадамжийг тодорхойлох;
2. Ажилтны боловсрол, мэргэжил, сургалт, ур чадвар, туршлагад үндэслэн шаардлагатай чадамжтай эсэхийг үнэлэх;
3. Чадамжийн хэрэгцээ, зөрүүг тодорхойлж, сургалт, мэргэжлийн хөгжил, туршлага солилцох болон бусад тохиромжтой арга хэмжээг төлөвлөх;
4. Чадамжийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;
5. Ажилтны чадамжийг нотлох холбогдох баримтжуулсан мэдээллийг хадгалах.

Багш нарын сургалт, судалгаа, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр, холбогдох журам, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан дэмжинэ.
Удирдах, гүйцэтгэх болон үйлчилгээний ажилтнуудын чадамжийн хэрэгцээг тухайн ажлын байрны онцлог, гүйцэтгэлийн үнэлгээ, байгууллагын үйл ажиллагааны шаардлагад үндэслэн тодорхойлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
Чадамжийг хөгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг холбогдох нэгжүүд үнэлж, хүний нөөцийн төлөвлөлт, ажилтны хөгжил болон НМТ-ийн сайжруулалтад ашиглана.
Холбогдох баримт бичиг:

- Хүний нөөцийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/009)
- МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр
- Багш, ажилтны хөгжлийг дэмжих холбогдох журам
- МУИС-ийн профессор багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх холбогдох журам
- МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх холбогдох журам
- Албан тушаалын тодорхойлолтууд

7.2.2. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС нь тусгай хэрэгцээт суралцагчдад боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, тэгш боломжтой хүргэхэд оролцох багш, ажилтнуудын шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг хөгжүүлэхэд анхаарна.
Тусгай хэрэгцээт суралцагчидтай ажиллах холбогдох багш, ажилтнуудын чадамжийн хэрэгцээг тодорхойлохдоо дараах асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Тусгай хэрэгцээт суралцагчдын суралцах онцлог, хэрэгцээ, дэмжлэгийн шаардлагыг ойлгох;
2. Сургалтын материал, арга зүй, үнэлгээний хэлбэрийг суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулах;
3. Хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид сургалтын орчин, харилцааг дэмжих;
4. Шаардлагатай дэмжлэг, тохируулга үйлчилгээг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;
5. Суралцагчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаалах, эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх.

МУИС нь тусгай хэрэгцээт суралцагчдад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сургалтын үйл ажиллагааны журам, холбогдох зөвлөмж, хөтөлбөр болон бусад баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Багш, ажилтнуудын шаардлагатай чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, мэдээлэл, арга зүйн дэмжлэгийн хэрэгцээг холбогдох нэгжүүд тодорхойлж, боломжит нөөц, зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- “Хичээлийн тохируулга үйлчилгээ” багш, оюутанд зориулсан зөвлөмж
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр
- МУИС-ийн оюутны дотуур байрны журам

7.3. Мэдлэг, ойлголт

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) хэрэгжилт, үр нөлөөнд нөлөөлөх өөрийн хяналтад ажиллаж буй багш, ажилтан болон бусад холбогдох этгээдэд НМТ-ийн бодлого, зорилт, холбогдох шаардлага, өөрсдийн үүрэг, оролцоо, хариуцлагын талаарх мэдлэг, ойлголтыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараах мэдээллийг хүргэнэ. Үүнд:

1. МУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, стратегийн зорилтууд;
2. НМТ-ийн бодлого, холбогдох зорилтууд;
3. НМТ-ийн үр нөлөөг дээшлүүлэхэд өөрийн ажил үүрэг, үйл ажиллагаагаар оруулах хувь нэмэр;
4. Өөрийн чиг үүрэгт хамаарах бодлого, журам, стандарт болон бусад шаардлага;
5. НМТ-ийн шаардлагыг биелүүлээгүйгээс үүсэж болзошгүй үр дагавар.

МУИС нь бодлого, стратеги, НМТ-ийн зорилт болон холбогдох шаардлагыг байгууллагын албан ёсны цахим хуудас, дотоод мэдээллийн систем, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад тохиромжтой сувгаар мэдээлнэ.

Шинээр ажилд орж буй багш, ажилтнуудад байгууллагын бодлого, стратеги, дүрэм журам, ажил үүргийн шаардлага, НМТ-ийн холбогдох зохицуулалтыг чиглүүлэх сургалт болон бусад арга хэмжээгээр танилцуулна.

МУИС-ийн 2025–2030 оны стратегийн төлөвлөгөө, НМТ-ийн бодлого, зорилтуудын уялдааг холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ажил үүргийн хуваарилалт болон гүйцэтгэлийн үнэлгээгээр дамжуулан хангана.

НМТ-ийн шаардлагыг биелүүлээгүйгээс боловсролын үйлчилгээний чанар, суралцагч болон бусад сонирхогч талуудын сэтгэл ханамж, үйл ажиллагааны үр дүн, хууль тогтоомж болон стандартын шаардлагын биелэлтэд сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүйг холбогдох ажилтнуудад ойлгуулна.

Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөг сургалтын үнэлгээ, ажилтны санал хүсэлт, гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудит болон бусад тохиромжтой арга хэрэгслээр үнэлж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлнэ.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө 2025–2030
- НМТ-ийн бодлого, зорилтууд
- МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- Хүний нөөцийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/009)
- Багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний холбогдох журам

7.4. Харилцаа холбоо

7.4.1. Ерөнхий зүйл

МУИС нь НМТ-ийн хэрэгжилттэй холбоотой дотоод болон гадаад харилцаа холбооны хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, холбогдох мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй, цаг тухайд нь хүргэх зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

НМТ-ийн харилцаа холбоог **“Харилцааны матриц” (NUM/EOMS/FMT/013)**-ын дагуу төлөвлөж, зохион байгуулна.

Харилцааны матрицад дараах мэдээллийг тусгана. Үүнд:

1. Ямар мэдээлэл хүргэх;
2. Мэдээлэл хүргэх зорилго;
3. Хэзээ, ямар давтамжтай мэдээлэх;
4. Хэнд мэдээлэх;
5. Ямар суваг, арга хэлбэрээр мэдээлэх;
6. Мэдээлэл хүргэх хариуцсан нэгж, албан тушаалтан.

Харилцаа холбоог байгууллагын албан ёсны цахим хуудас, дотоод мэдээллийн систем, албан бичиг, цахим шуудан, уулзалт, хурал, сургалт, хэлэлцүүлэг болон бусад тохиромжтой сувгаар хэрэгжүүлнэ.

7.4.2. Харилцаа холбооны зорилго

МУИС нь дотоод болон гадаад харилцаа холбоог дараах зорилгоор хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын бодлого, стратеги, зорилт, үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг сонирхогч талуудад хүргэх;
2. Суралцагч болон бусад сонирхогч талуудын санал хүсэлт, хэрэгцээ, хүлээлтийг хүлээн авч, харгалзан үзэх;
3. Байгууллагын нэгжүүдийн үйл ажиллагаа, шийдвэр, үүрэг хариуцлагын уялдааг хангах;
4. НМТ-ийн хэрэгжилт, гүйцэтгэл, өөрчлөлт, сайжруулалтын талаарх мэдээлэл солилцоог дэмжих;
5. Холбогдох сонирхогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангах.

7.4.3. Харилцаа холбооны зохицуулалт

МУИС нь суралцагч болон бусад сонирхогч талуудтай харилцахдаа дараах чиглэлийн мэдээлэл, харилцаа холбоог холбогдох журмын дагуу зохицуулна. Үүнд:

- Байгууллагын бодлого, стратегийн төлөвлөгөө, холбогдох шийдвэр;
- Боловсролын хөтөлбөр, үйлчилгээний агуулга, зохион байгуулалт, хэрэгжилт;
- Элсэлт, бүртгэл, суралцах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, лавлагаа;
- Суралцагчийн сургалтын явц, үнэлгээ, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл;
- Өргөдөл, гомдол, санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгаа болон тэдгээрийн шийдвэрлэлт;
- Боловсролын үйлчилгээ, НМТ-ийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, сайжруулалт.

Суралцагчийн хувийн мэдээлэл, сургалтын гүйцэтгэл, үнэлгээний мэдээллийг хүргэхдээ мэдээллийн нууцлал, хамгаалалт, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын журмыг мөрдөнө.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох журмын дагуу хүлээн авч, шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд асуудлыг цаашид хандах эрх бүхий нэгж, байгууллагын талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэнэ.

Харилцаа холбооны зохицуулалтын хэрэгжилт, үр нөлөөг холбогдох нэгжүүд хянаж, шаардлагатай тохиолдолд харилцааны матриц болон мэдээлэл солилцооны арга хэлбэрийг шинэчилнэ.

Холбогдох баримт бичиг:

- Харилцааны матриц (NUM/EOMS/FMT/013)
- МУИС-ийн албан хэрэг хөтлөлтийн журам
- Цахим харилцаа, мэдээлэл солилцоог зохицуулсан холбогдох журам
- Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх холбогдох журам

7.5. Баримтжуулсан мэдээлэл

7.5.1. Ерөнхий зүйл

МУИС нь НМТ-ийн үр нөлөөтэй хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны шаардлагад нийцсэн байдлыг нотлох зорилгоор ISO 9001:2015 болон ISO 21001:2018 стандартын шаардсан, мөн

байгууллагаас шаардлагатай гэж тодорхойлсон баримтжуулсан мэдээллийг бүрдүүлж, хадгалж, хянана.

НМТ-ийн баримтжуулсан мэдээллийн бүтэц, хамрах хүрээг байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны онцлог, үйл явцын нарийн төвөгтэй байдал, тэдгээрийн харилцан хамаарал, ажилтнуудын чадамж болон холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагыг харгалзан тодорхойлно.

НМТ-ийн баримтжуулсан мэдээлэлд бодлого, зорилт, гарын авлага, журам, үйл явцын зураглал, төлөвлөгөө, заавар, маягт, бүртгэл, тайлан болон шаардлагатай бусад мэдээлэл хамаарна.

7.5.2. Баримтжуулсан мэдээллийг бий болгох, шинэчлэх

МУИС нь баримтжуулсан мэдээллийг бий болгох, шинэчлэхдээ дараах шаардлагыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Баримт бичгийн нэр, код, хувилбар, огноо болон бусад таних мэдээллийг тодорхойлох;
2. Баримт бичгийн агуулга, хэлбэр, ашиглах хэрэгсэл, хадгалах орчныг тохиромжтойгоор тогтоох;
3. Баримт бичгийг ашиглахаас өмнө холбогдох эрх бүхий албан тушаалтнаар хянуулах, баталгаажуулах;
4. Баримт бичигт оруулсан өөрчлөлт, шинэчлэлийг тодорхой бүртгэж, хувилбарын хяналтыг хэрэгжүүлэх.

Баримтжуулсан мэдээллийг бий болгох, шинэчлэх үйл ажиллагааг **“Баримтжуулсан мэдээллийг хянах журам” (NUM/EOMS/PRO/002)**-ын дагуу зохицуулна.

7.5.3. Баримтжуулсан мэдээллийн хяналт

МУИС нь НМТ-ийн баримтжуулсан мэдээллийг шаардлагатай үед ашиглах боломжтой, тохиромжтой хэлбэрээр хадгалах, зөвшөөрөлгүй өөрчлөлт, алдагдал, гэмтэл болон зохисгүй ашиглалтаас хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

Баримтжуулсан мэдээллийн хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1. Баримт бичгийг түгээх, ашиглах эрх, хүртээмжийг зохицуулах;
2. Баримт бичгийг хадгалах, хамгаалах, сэргээн ашиглах боломжийг хангах;
3. Баримт бичгийн өөрчлөлт, хувилбарын хяналтыг хэрэгжүүлэх;
4. Баримтжуулсан мэдээллийг хадгалах хугацаа, архивлах болон устгах зохицуулалтыг мөрдөх;
5. НМТ-ийн үйл ажиллагаанд шаардлагатай гаднын гаралтай баримтжуулсан мэдээллийг тодорхойлж, зохих хяналтад байлгах;
6. Үйл ажиллагааны нотолгоо болгон хадгалж буй бүртгэл, тайлан, бусад мэдээллийг зөвшөөрөлгүй өөрчлөхөөс хамгаалах.

Баримтжуулсан мэдээллийн бүртгэл, хувилбарын хяналт, хадгалалт, түгээлт болон ашиглалтыг холбогдох нэгжүүд батлагдсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

Холбогдох баримт бичиг:

- Баримтжуулсан мэдээллийг хянах журам (NUM/EOMS/PRO/002, Хавсралт XXIX)
- МУИС-ийн албан хэрэг хөтлөлтийн журам
- НМТ-ийн баримт бичгийн нэгдсэн жагсаалт (NUM/EOMS/FMT/09)
- НМТ-ийн бүртгэлийн нэгдсэн жагсаалт (NUM/EOMS/FMT/11)
- Холбогдох үйл явцын гарын авлага, журам, заавар, маягт, бүртгэл

БҮЛЭГ 8. АЖИЛЛАГАА

8.1. Ажиллагааны төлөвлөлт ба хяналт

8.1.1. Ерөнхий зүйл

МУИС нь эрхэм зорилго, стратегийн зорилт болон нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) шаардлагад нийцүүлэн сургалт, судалгаа, суралцагчдад үзүүлэх үйлчилгээ болон холбогдох дэмжих үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж, хянана.

Сургалт, судалгаа, суралцагчдад үзүүлэх үйлчилгээний үндсэн үйл ажиллагааг хичээлийн жилийн нэгдсэн хуанли, сургалтын хөтөлбөр, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан бусад баримт бичигтэй уялдуулан зохион байгуулна.

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангах, энэхүү гарын авлагын 6.1-д тодорхойлсон эрсдэл, боломжид чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг төлөвлөж, хянана. Үүнд:

1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон холбогдох үйл явцад тавигдах шаардлагыг тодорхойлох;
2. Үйл явцын хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур, хяналтын арга хэмжээг тогтоох;
3. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, дэд бүтэц, санхүүжилт, мэдээлэл болон бусад нөөцийг тодорхойлох;
4. Үйл явцыг тогтоосон шалгуур, шаардлагын дагуу хэрэгжүүлж, хяналт тавих;
5. Үйл ажиллагаа төлөвлөсний дагуу хэрэгжсэн болон боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлоход шаардлагатай баримтжуулсан мэдээллийг бүрдүүлж, хадгалах;
6. Хяналт, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай залруулга, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

МУИС нь төлөвлөсөн өөрчлөлтийг холбогдох журмын дагуу удирдаж, төлөвлөөгүй өөрчлөлтийн үр дагаврыг үнэлэн, сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авна.

Гаднаас нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ болон гаднын байгууллагаар гүйцэтгүүлж буй үйл явцын хяналтыг холбогдох худалдан авалт, гэрээний зохицуулалт болон НМТ-ийн шаардлагын дагуу хэрэгжүүлнэ.

8.1.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний тусгай ажиллагааны төлөвлөлт ба хяналт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалтыг сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн гарын авлага, сургалтын үйл ажиллагааны журам болон холбогдох баримт бичгийн дагуу зохион байгуулна.

Боловсролын үйлчилгээний төлөвлөлт, хяналтад дараах асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөр, хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлох;
2. Суралцагчдын хэрэгцээ, онцлогт нийцсэн, хүртээмжтэй сургалтын арга зүй, хэлбэр, орчныг төлөвлөх;
3. Сургалтын үр дүнг үнэлэх арга, шалгуур, хэрэгслийг тодорхойлох;
4. Суралцагчдын сургалтын явц, ахиц, суралцахуйн үр дүнг үнэлэх;
5. Сургалтын хэрэгжилт, үнэлгээний үр дүн, санал хүсэлтэд үндэслэн сайжруулах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх;
6. Суралцагчдад шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжих үйлчилгээг төлөвлөж, зохион байгуулах.

Сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, сургалтын арга зүй, үнэлгээ болон холбогдох үйл ажиллагааны хэрэгжилтэд эрх бүхий нэгжүүд чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавьж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлнэ.

Боловсролын үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний үр дүнг холбогдох мэдээллийн систем, тайлан, бүртгэл болон бусад баримтжуулсан мэдээллээр нотолно.

8.1.3. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС нь тусгай хэрэгцээт суралцагчдын боловсрол эзэмших тэгш боломж, сургалтын хүртээмж, оролцоог дэмжих зорилгоор тэдний хэрэгцээ, суралцах онцлог, холбогдох хууль тогтоомж, байгууллагын зохицуулалт болон боломжит нөөцийг харгалзан шаардлагатай дэмжлэг, тохируулга үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Тусгай хэрэгцээт суралцагчдад үзүүлэх дэмжлэг, тохируулгыг тодорхойлохдоо суралцагчийн хүсэлт, хэрэгцээ, холбогдох мэргэжлийн зөвлөмж, сургалтын хөтөлбөрийн шаардлага болон суралцахуйн үр дүнг харгалзан үзнэ.

Дэмжлэг, тохируулга үйлчилгээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгцээ, боломжид нийцүүлэн авч үзнэ. Үүнд:

1. Суралцагчийг сургалтын орчин, үйл ажиллагаанд дасан зохицоход шаардлагатай мэдээлэл, чиглүүлэг, зөвлөгөө өгөх;
2. Сургалтын материал, мэдээлэл, заах арга зүй, суралцах үйл ажиллагааны хэлбэрийг хүртээмжтэй болгох;
3. Суралцагчийн онцлогт нийцүүлэн хичээлийн зохион байгуулалт, сургалтын арга, үнэлгээний хэлбэрт шаардлагатай тохируулга хийх;
4. Сургалтын хөтөлбөрийн шаардлага, суралцахуйн үр дүнг хадгалан, суралцагчийн хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлэх;
5. Хичээл сонголт, сургалтын үйлчилгээ, мэдээлэл авах боломжийг холбогдох журмын хүрээнд дэмжих;
6. Шаардлагатай тохиолдолд сургалт хариуцсан нэгж, багш, суралцагчийн үйлчилгээний нэгж болон бусад холбогдох талуудын хамтын ажиллагааг зохион байгуулах;
7. Суралцагчийн хэрэгцээнд нийцсэн туслах хэрэгсэл, технологи, дэд бүтэц болон бусад дэмжлэгийн боломжийг тодорхойлох.

Тусгай хэрэгцээт суралцагчдад үзүүлэх дэмжлэг, тохируулга нь сургалтын хөтөлбөрийн үндсэн шаардлага, суралцахуйн үр дүн, үнэлгээний шударга байдлыг алдагдуулахгүйгээр суралцах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Холбогдох нэгжүүд нь үзүүлсэн дэмжлэг, тохируулгын хэрэгжилт, үр нөлөөг суралцагчийн санал хүсэлт, сургалтын явц болон бусад тохиромжтой мэдээлэлд үндэслэн хянан үзэж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлнэ.

Суралцагчийн хувийн болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомж, байгууллагын журмын дагуу хамгаална.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын нэгдсэн хуанли
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- Сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн гарын авлага
- Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын холбогдох журам
- Өөрчлөлтийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/006, Хавсралт VII)
- Худалдан авалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/012, Хавсралт XIX)
- “Хичээлийн тохируулга үйлчилгээ” багш, оюутанд зориулсан зөвлөмж
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих холбогдох хөтөлбөр, журам

8.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага

8.2.1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох

МУИС нь суралцагч болон бусад холбогдох сонирхогч талуудад санал болгох боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо байгууллагын эрхэм зорилго, стратегийн зорилт, хууль тогтоомж, холбогдох стандарт, суралцагчдын хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт болон боловсролын салбарын хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзнэ.

Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

1. Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон зохицуулалт, стандартын шаардлага;
2. МУИС-ийн стратегийн төлөвлөгөө, боловсролын бодлого, холбогдох зорилтууд;
3. Суралцагч, төгсөгч, ажил олгогч болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт, санал хүсэлт, судалгааны үр дүн;
4. Тусгай хэрэгцээт суралцагчдын сургалтын хүртээмж, оролцоо, дэмжлэгийн шаардлага;
5. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, мэргэжлийн ур чадвар, чадамжийн шаардлага;
6. Үндэсний болон олон улсын дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлага;
7. Судалгаа, шинжилгээ, хөтөлбөрийн үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үр дүн;
8. Сургалт, судалгааны орчны эрүүл ахуй, аюулгүй байдал болон бусад холбогдох шаардлага.

Тодорхойлсон шаардлагыг сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр болон үнэлгээний арга, шалгуурт холбогдох журмын дагуу тусгана.

Сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн уялдааг тодорхойлж, хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалтын үйл ажиллагаанд ашиглана. МУИС нь санал болгож буй боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангах боломж, нөөц, зохион байгуулалтыг холбогдох үйл явцын хүрээнд хянан үзнэ.

8.2.2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг мэдээлэх

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээллийг суралцагч, элсэгч болон бусад холбогдох сонирхогч талуудад үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ.

Мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, элсэлтийн мэдээллийн систем, оюутны портал, сургалтын мэдээллийн систем, оюутны гарын авлага болон бусад тохиромжтой сувгаар хүргэнэ. Суралцагч, элсэгчдэд дараах мэдээллийг холбогдох үе шатанд танилцуулна. Үүнд:

1. МУИС-ийн танилцуулга, сургалтын хөтөлбөр, олгох боловсролын зэрэг, мэргэшил;
2. Элсэлт, бүртгэл, суралцах нөхцөл, шаардлага;
3. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн;
4. Сургалтын зохион байгуулалт, хичээл сонголт, суралцагчийн үнэлгээний журам, шалгуур;
5. Сургалтын төлбөр, холбогдох бусад төлбөр, санхүүгийн нөхцөл;
6. Тэтгэлэг, хөнгөлөлт, дэмжлэг, суралцагчдад үзүүлэх үйлчилгээ;
7. Оюутны дотуур байр болон бусад дэмжих үйлчилгээний нөхцөл;
8. Суралцагчийн эрх, үүрэг, суралцах гэрээ, холбогдох дүрэм, журам;
9. Өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх зохицуулалт.

   МУИС нь боловсролын үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, шаардлагыг өөрчлөх тохиолдолд холбогдох суралцагч болон сонирхогч талуудад зохих хугацаанд мэдээлэх зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

8.2.3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагыг хянан үзэх, өөрчлөх

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага шинээр тогтоогдох, өөрчлөгдөх тохиолдолд тухайн өөрчлөлтийн үндэслэл, хамрах хүрээ, хэрэгжүүлэх боломж болон сургалтын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг холбогдох журмын дагуу хянан үзнэ.

Шаардлагын өөрчлөлттэй холбоотойгоор сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, элсэлтийн нөхцөл болон бусад холбогдох баримт бичигт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр оруулна.

Өөрчлөлт нь суралцагчдын суралцах нөхцөл, сургалтын үр дүн, төлбөр, үйлчилгээ болон бусад эрх ашигт нөлөөлөх тохиолдолд холбогдох мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хэрэгжилтийг зохицуулна.

Шаардлагыг хянан үзсэн үр дүн, гарсан шийдвэр, холбогдох өөрчлөлтийн баримтжуулсан мэдээллийг шаардлагын дагуу хадгална.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх холбогдох журам
- Суралцагч шилжүүлэн суралцуулах журам
- Хичээл дүйцүүлэх холбогдох журам
- МУИС-ийн суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам
- Сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр

8.3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт

8.3.1. Ерөнхий зүйл

МУИС нь суралцагч, ажил олгогч, мэргэжлийн байгууллага болон бусад холбогдох сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалт, хяналт, баталгаажуулалт, шинэчлэлийн үйл явцыг хэрэгжүүлнэ.

Сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтыг дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавигдах холбогдох нийтлэг шаардлага, мэргэжлийн стандарт, МУИС-ийн сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам болон бусад холбогдох зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх, хянан хэлэлцэх, батлах үйл ажиллагааг байгууллагын холбогдох журмаар тогтоосон эрх хэмжээ, үе шат, шаардлагын дагуу зохион байгуулна.

Сургалтын хөтөлбөрийн чанар, шаардлагад нийцсэн байдлыг дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаагаар хянаж, холбогдох шаардлага, зохицуулалтын дагуу үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэл, хөндлөнгийн үнэлгээнд хамруулна.

8.3.2. Дизайн ба боловсруулалтын төлөвлөлт

МУИС нь сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулах, шинэчлэх үйл ажиллагааг төлөвлөхдөө хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ, суралцахуйн үр дүн, оролцогч талуудын хэрэгцээ, холбогдох шаардлага, нөөц болон хэрэгжүүлэх хугацааг харгалзан үзнэ. Дизайн ба боловсруулалтын үйл явцыг төлөвлөхдөө дараах асуудлыг тодорхойлно. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын зорилго, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх хугацаа;
2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүн;
3. Хөтөлбөр боловсруулах, хянан хэлэлцэх, батлах үйл ажиллагаанд оролцох нэгж, албан тушаалтны үүрэг, хариуцлага, эрх хэмжээ;
4. Дизайн, боловсруулалтын үе шат бүрд хэрэгжүүлэх хяналт, дүн шинжилгээ, шалган батлах болон баталгаажуулах арга хэмжээ;
5. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүжилт, дэд бүтэц, сургалтын материал, технологи болон бусад нөөц;
6. Суралцагч, төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн байгууллага болон бусад сонирхогч талуудын оролцоо, санал хүсэлтийг авах хэрэгцээ;
7. Сургалтын арга зүй, үнэлгээний арга, шалгуур болон сургалтын орчны хүртээмж;
8. Сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, материалын уялдаа, шинэчлэл, дахин ашиглах болон хүртээмжтэй байдлын шаардлага;
9. Хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын үр дүнг нотлоход шаардлагатай баримтжуулсан мэдээлэл;
10. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хянан үзэх, сайжруулах зохицуулалт.

Сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын үйл явцад нотолгоонд суурилсан хандлагыг баримталж, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сонирхогч талуудын санал хүсэлт, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, магадлан итгэмжлэлийн дүгнэлт болон холбогдох бусад мэдээллийг ашиглана.
Хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт болон баталгаажуулалтын үр дүнг холбогдох журмын дагуу баримтжуулна.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага
- Бакалаврын төгсөгчдөд тавих холбогдох нийтлэг шаардлага
- Сургалтын хөтөлбөрийн үндсэн баримт бичиг
- Сургалтын хөтөлбөрийн дагалдах баримт бичиг

8.3.3. Дизайн ба боловсруулалтын орц

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтад шаардлагатай орцыг тодорхойлохдоо дараах асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Үндэсний болон олон улсын дээд боловсролын хөгжлийн чиг хандлага;
2. Суралцагч, төгсөгч, ажил олгогч болон бусад холбогдох сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт;
3. Өмнө хэрэгжүүлсэн ижил төстэй сургалтын хөтөлбөр, тэдгээрийн үнэлгээ, хэрэгжилтээс олж авсан туршлага;
4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам болон мэргэжлийн шаардлага;
5. Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой эрсдэл, боломж, болзошгүй үр дагавар;
6. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн;
7. Сургалт, суралцах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай багшлах бүрэлдэхүүн, сургалтын орчин, технологи, санхүүгийн болон бусад нөөц.

МУИС нь дизайн, боловсруулалтын орцыг бүрэн, ойлгомжтой, хоёрдмол утгагүй, тухайн хөтөлбөрийн зорилго, шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзнэ. Орцын шаардлагад зөрчил, тодорхойгүй байдал илэрсэн тохиолдолд холбогдох нэгжүүд шийдвэрлэж, шаардлагатай залруулгыг хийнэ.
Сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулах, шинэчлэхдээ холбогдох журмаар тогтоосон загвар, маягтын дагуу сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, хичээлийн залгамж холбоо, суралцагчийн суралцах жишиг төлөвлөгөө болон шаардлагатай бусад баримт бичгийг боловсруулна.
Дизайн, боловсруулалтын орц болон түүнийг хянан үзсэн үр дүнгийн баримтжуулсан мэдээллийг хадгална.

8.3.4. Дизайн ба боловсруулалтын хяналт

8.3.4.1. Ерөнхий зүйл

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн, боловсруулалтын үйл явцын үе шат бүрд шаардлагатай хяналт, дүн шинжилгээ, шалган батлах болон баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
Дизайн, боловсруулалтын хяналт нь дараах шаардлагыг хангахад чиглэнэ. Үүнд:

1. Дизайн, боловсруулалтын хүрэх үр дүнг тодорхойлсон байх;
2. Дизайн, боловсруулалтын үр дүн нь тогтоосон шаардлагыг хангах боломжтой эсэхийг хянан үзэх;

3. Дизайн, боловсруулалтын гаралт нь орцын шаардлагад нийцэж байгааг шалган батлах;
4. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зориулалт, хэрэглээний шаардлагыг хангаж байгааг баталгаажуулах;
5. Хяналт, дүн шинжилгээ, шалган батлах болон баталгаажуулах явцад илэрсэн асуудлыг шийдвэрлэх;
6. Хэрэгжүүлсэн хяналт, үнэлгээ, гарсан шийдвэр болон авсан арга хэмжээний баримтжуулсан мэдээллийг хадгалах.

Дизайн, боловсруулалтын хяналтыг холбогдох хөтөлбөрийн хороо, сургалт хариуцсан нэгж болон эрх бүхий бусад нэгж, албан тушаалтан батлагдсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.3.4.2. Боловсролын үйлчилгээний дизайн ба боловсруулалтын хяналт

МУИС нь боловсролын үйлчилгээний дизайн, боловсруулалтын явцад сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, сургалтын зохион байгуулалт, суралцагчдад үзүүлэх дэмжих үйлчилгээ болон холбогдох шаардлагын уялдааг хянана.

Хяналтын хүрээнд боловсролын үйлчилгээний агуулга, хэлбэр, хэрэгжүүлэх арга, шаардагдах нөөц болон хүрэх үр дүн нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Дизайн, боловсруулалтын явцад илэрсэн зөрчил, дутагдал, сайжруулах шаардлагатай асуудлыг холбогдох нэгжүүд хянан шийдвэрлэж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг баримтжуулна.

8.3.4.3. Сургалтын хөтөлбөрийн дизайн ба боловсруулалтын хяналт

МУИС нь сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын явцад хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, сургалтын арга зүй, суралцагчийн үнэлгээ болон шаардлагатай нөөцийн уялдааг хянана.

Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ, боловсролын түвшинд нийцсэн байх;
2. Хөтөлбөрийг амжилттай дүүргэснээр суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, чадамжийг тодорхойлсон байх;
3. Суралцахуйн үр дүнг үнэлэх боломжтой шалгуур, үзүүлэлттэй байх;
4. Тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, уялдаатай, зохих хугацаанд хэрэгжих боломжтой байх.

Суралцах үйл ажиллагаа, сургалтын арга зүй нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хүрэхэд чиглэсэн, боловсролын түвшин, хичээлийн онцлог, суралцагчдын хэрэгцээнд тохирсон байна.

Сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын явцад суралцагчдын идэвхтэй оролцоо, явцын үнэлгээ, эргэх холбоо, сургалтын хүртээмж болон суралцах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг харгалзан үзнэ.

8.3.4.4. Суралцагчийн үнэлгээний дизайн ба боловсруулалтын хяналт

МУИС нь суралцагчийн үнэлгээний арга, шалгуур, хэрэгслийг боловсруулахдаа сургалтын хөтөлбөр болон хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулна.

Үнэлгээний дизайн, боловсруулалтын хяналт нь дараах шаардлагыг хангахад чиглэнэ. Үүнд:

1. Үнэлгээний арга, шалгуур нь үнэлэхээр төлөвлөсөн суралцахуйн үр дүнтэй шууд холбоотой байх;
2. Үнэлгээний шалгуур, онооны системийг тодорхойлж, суралцагчдад ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлэх;
3. Үнэлгээг шударга, ил тод, ялгаварлан гадуурхалтаас ангид хэрэгжүүлэх;

4. Үнэлгээний арга, хэрэгслийн тохиромжтой, найдвартай байдлыг холбогдох журмын дагуу хянах;
5. Шаардлагатай тохиолдолд тусгай хэрэгцээт суралцагчдад үнэлгээний зохистой тохируулга хийх боломжийг харгалзан үзэх.

Үнэлгээний дизайн, боловсруулалт, хяналтын үр дүнг сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр, үнэлгээний материал болон холбогдох баримтжуулсан мэдээллээр нотолно.

8.3.5. Дизайн ба боловсруулалтын гаралт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн, боловсруулалтын гаралт нь тогтоосон орцын шаардлагыг хангаж, сургалтын хөтөлбөр болон боловсролын үйлчилгээг хэрэгжүүлэхэд тохиромжтой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Дизайн, боловсруулалтын гаралт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дизайн, боловсруулалтын орцын шаардлагад нийцсэн байх;
2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэгжүүлэх болон холбогдох дэмжих үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой байх;
3. Мониторинг, хэмжилт, үнэлгээний шаардлага болон хүлээн авах шалгуурыг тодорхойлсон байх;
4. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг зориулалтын дагуу, үр дүнтэй, аюулгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн шинж чанарыг тодорхойлсон байх;
5. Хэрэгжүүлэх, хянах, үнэлэхэд шаардлагатай баримтжуулсан мэдээллийг бүрдүүлсэн байх.

Сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын гаралтад сургалтын хөтөлбөрийн үндсэн болон дагалдах баримт бичиг, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, суралцахуйн үр дүн, үнэлгээний арга, шалгуур болон бусад холбогдох баримт бичиг хамаарна.

Сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулах, шинэчлэх явцад холбогдох хөтөлбөрийн хороодоор хянан хэлэлцүүлж, батлагдсан журмын дагуу шийдвэрлэнэ.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэр;
- Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэр;
- Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлын шийдвэр;
- Сургалтын хөтөлбөрийн үндсэн болон дагалдах баримт бичиг;
- Хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын хяналт, үнэлгээний холбогдох баримтжуулсан мэдээлэл.

8.3.6. Дизайн ба боловсруулалтын өөрчлөлт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургалтын хөтөлбөрийн дизайн, боловсруулалтын явцад болон хэрэгжүүлсний дараа шаардлагатай өөрчлөлтийг тодорхойлж, хянан үзэж, холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

Өөрчлөлтийг хянан үзэхдээ сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, сургалтын агуулга, зохион байгуулалт, үнэлгээ, суралцагчдын эрх ашиг болон холбогдох бусад шаардлагад үзүүлэх нөлөөллийг үнэлнэ.

Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн хэрэгцээг тодорхойлоход хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, төгсөгчдийн судалгаа, ажил олгогчдын санал хүсэлт, суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа, магадлан итгэмжлэлийн дүгнэлт болон бусад холбогдох мэдээллийг ашиглана.

Дизайн, боловсруулалтын өөрчлөлтийг эрх бүхий нэгж, албан тушаалтан холбогдох журмын дагуу хянан хэлэлцэж, баталгаажуулна.

МУИС нь дараах баримтжуулсан мэдээллийг хадгална. Үүнд:

1. Дизайн, боловсруулалтад оруулсан өөрчлөлт;
2. Өөрчлөлтийг хянан үзсэн үр дүн;
3. Өөрчлөлтийг зөвшөөрсөн, баталсан шийдвэр;

4. Өөрчлөлтийн болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ.

Холбогдох баримтжуулсан мэдээлэл:

- Хөтөлбөрийн хороодын хурлын тэмдэглэл, шийдвэр;
- Төгсөх түвшний суралцагчдын судалгааны үр дүн;
- Төгсөгчдийн судалгааны үр дүн;
- Суралцагч болон бусад сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа;
- Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, шинэчлэлийн холбогдох баримт бичиг.

8.4. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт

8.4.1. Ерөнхий зүйл

МУИС нь гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь байгууллагын болон холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээний шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.

Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг дараах тохиолдолд хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Гаднаас нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг МУИС-ийн боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаанд нэгтгэн ашиглах;
2. Гаднын нийлүүлэгчээс бүтээгдэхүүн, үйлчилгээг МУИС-ийн нэрийн өмнөөс суралцагч болон бусад хэрэглэгчдэд шууд хүргэх;
3. МУИС-ийн шийдвэрийн дагуу тодорхой үйл явц, түүний хэсгийг гаднын нийлүүлэгчээр гүйцэтгүүлэх.

МУИС нь гаднын нийлүүлэгчдийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх чадварт үндэслэн тэдгээрийг үнэлэх, сонгох, гүйцэтгэлд мониторинг хийх, дахин үнэлэх шалгуурыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

Гаднын нийлүүлэгчийг сонгох, гэрээ байгуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ хүлээн авах, гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэх болон шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, худалдан авалтын журам, үйл явцын гарын авлагын дагуу зохион байгуулна.

МУИС нь гаднын нийлүүлэгчдийн үнэлгээ, сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн хяналт, дахин үнэлгээ болон тэдгээрийн үр дүнд үндэслэн авсан арга хэмжээний баримтжуулсан мэдээллийг хадгална.

Холбогдох баримт бичиг:

- Худалдан авалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/012, Хавсралт XIX)
- Худалдан авах ажиллагааны холбогдох журам, заавар
- Гаднын нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн үнэлгээ, хүлээн авалтын баримтжуулсан мэдээлэл

8.4.2. Хяналтын төрөл ба цар хүрээ

МУИС нь гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг суралцагч болон бусад холбогдох сонирхогч талуудад шаардлагын дагуу, тогтвортой хүргэх чадварт сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангана.

Гаднын нийлүүлэгчид тавих хяналтын төрөл, цар хүрээг тодорхойлохдоо дараах асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Гаднаас гүйцэтгүүлж буй үйл явцыг НМТ-ийн холбогдох хяналтад хамруулах;
2. Гаднын нийлүүлэгч болон нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага, хяналтын шалгуурыг тогтоох;
3. Нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, шаардлагад нийцсэн байдал нь МУИС-ийн үйл ажиллагаанд үзүүлэх боломжит нөлөөллийг үнэлэх;
4. Гаднын нийлүүлэгчийн хэрэгжүүлж буй хяналтын үр нөлөөг харгалзан үзэх;

5. Шаардлагатай тохиолдолд нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний шалгалт, хүлээн авалт, баталгаажуулалт болон бусад хяналтын арга хэмжээг тодорхойлох.

Хяналтын үр дүн, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээний холбогдох баримтжуулсан мэдээллийг хадгална.

8.4.3. Гаднын нийлүүлэгчид өгөх мэдээлэл

МУИС нь гаднын нийлүүлэгчид тавих шаардлагыг мэдээлэхээс өмнө тэдгээрийн бүрэн, тодорхой, тохиромжтой байдлыг хянан үзнэ.

Гаднын нийлүүлэгчид дараах шаардлагыг холбогдох гэрээ, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгээр мэдээлнэ. Үүнд:

1. Нийлүүлэх үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлага;
2. Ашиглах арга, үйл явц, тоног төхөөрөмж болон бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвшөөрөх, баталгаажуулах шаардлага;
3. Холбогдох ажилтнуудын мэргэшил, чадамжийн шаардлага;
4. МУИС болон гаднын нийлүүлэгчийн харилцан ажиллагаа, үүрэг, хариуцлага;
5. Гаднын нийлүүлэгчийн гүйцэтгэлд хийх хяналт, мониторингийн шаардлага;
6. Шаардлагатай тохиолдолд гаднын нийлүүлэгчийн байранд МУИС болон холбогдох эрх бүхий этгээдээс хийх шалгалт, баталгаажуулалтын зохицуулалт.

Холбогдох баримт бичиг:

- Худалдан авалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/012, Хавсралт XIX)
- МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- МУИС-д зөвлөх, гэрээт, зочин профессор, цагийн багш ажиллуулах журам
- МУИС-ийн үйлчилгээний нэгдсэн стандарт
- Хамтын ажиллагааны гэрээ байгуулах журам
- Гаднын нийлүүлэгчтэй байгуулсан холбогдох гэрээ, хүлээн авалтын баримт бичиг

8.5. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх

8.5.1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхэд тавих хяналт

8.5.1.1. Ерөнхий зүйл

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөсөн нөхцөл, тогтоосон шалгуур, холбогдох хууль тогтоомж, стандарт болон байгууллагын дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, хянана.

Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтад дараах шаардлагыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримтжуулсан мэдээллээр хангах;
2. Мониторинг, хэмжилт, үнэлгээний тохиромжтой нөөц, арга хэрэгслийг ашиглах;
3. Үйл явц болон түүний гаралтыг хянах шалгуурыг тогтоож, шаардлагатай үе шатанд мониторинг, үнэлгээ хийх;
4. Сургалт, судалгаа, суралцагчдад үзүүлэх үйлчилгээнд тохирсон дэд бүтэц, орчныг бүрдүүлэх;
5. Шаардлагатай чадамжтай багш, ажилтан, мэргэжилтнийг ажиллуулах;
6. Үйл ажиллагааны явцад хүний алдаанаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх;
7. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагад нийцсэн байдлыг нотлох баримтжуулсан мэдээллийг бүрдүүлж, хадгалах.

МУИС нь элсэлт, бүртгэл, сургалтын төлөвлөлт, хичээл сонголт, багшлахуй, суралцахуй, үнэлгээ, төгсөлт болон суралцагчдад үзүүлэх дэмжих үйлчилгээний үйл явцыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлнэ.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг багш, суралцагч, төгсөгч, ажил олгогч болон бусад сонирхогч талуудын санал хүсэлт, хөтөлбөрийн үнэлгээ, дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үр дүнд үндэслэн хянан үзэж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлнэ. Суралцагчийн төгсөлт, боловсролын зэрэг олгох үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрийн шаардлага, сургалтын үйл ажиллагааны журам болон холбогдох шийдвэрийн дагуу зохион байгуулна.

Үйл ажиллагааны явцад илэрсэн алдаа, зөрчил, үл тохирлыг холбогдох журмын дагуу хянаж, залруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Холбогдох баримт бичиг:

- Сургалтын тэнхимийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/001, Хавсралт IX)
- Багшлахуй ба суралцахуйн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/002, Хавсралт X)
- Оюутны хөгжлийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/006, Хавсралт XIV)
- Шалгалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/008, Хавсралт XVI)
- Стратегийн хөтөлбөрийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/015, Хавсралт XXII)
- Оюутны суралцахуйн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/016, Хавсралт XXIII)
- Сургалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/018, Хавсралт XXV)
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- МУИС-ийн үйлчилгээний нэгдсэн стандарт

8.5.1.2. Элсэлт

8.5.1.2.1. Элсэлтийн өмнөх мэдээлэл

МУИС нь элсэгчдэд сургалтын хөтөлбөр, элсэлтийн нөхцөл, шаардлага болон суралцах үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай мэдээллийг элсэлтийн өмнө хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хүргэнэ.

Элсэлтийн мэдээлэлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, олгох боловсролын зэрэг;
2. Элсэлтийн шалгуур, шаардлага, бүртгэлийн хугацаа, үе шат;
3. Сургалтын төлөвлөгөө, судлах хичээл, багц цаг болон хичээлийн залгамж холбоо;
4. Суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, суралцахуйн үр дүн;
5. Сургалтын төлбөр, холбогдох бусад нөхцөл;
6. Элсэлт, бүртгэлтэй холбоотой лавлагаа, мэдээлэл авах боломж.

Элсэлтийн мэдээллийг МУИС-ийн албан ёсны цахим хуудас, элсэлтийн бүртгэлийн систем болон бусад тохиромжтой сувгаар нийтэд мэдээлнэ.

8.5.1.2.2. Элсэлтийн нөхцөл

МУИС нь элсэлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлага, МУИС-ийн элсэлтийн журам болон Элсэлтийн үйл явцын гарын авлагын дагуу зохион байгуулна.

Элсэлтийн шалгуурыг тодорхойлохдоо дараах шаардлагыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Байгууллагын болон холбогдох хууль тогтоомжийн шаардлага;
2. Мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага;
3. Сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцах үйл ажиллагааны онцлогоос хамаарах нэмэлт шаардлага.

Элсэлтийн шалгуур, шийдвэр гаргах үйл явцыг холбогдох элсэгчдэд нэг мөр, шударга, ил тод хэрэгжүүлнэ.

Элсэлтийн бүртгэл, шалгуурын биелэлт, шийдвэр болон холбогдох мэдээллийг шаардлагын дагуу бүртгэж, хадгална.

Холбогдох баримт бичиг:

- Элсэлтийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/003, Хавсралт XI)

- Тухайн хичээлийн жилийн батлагдсан элсэлтийн журам
- Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсүүлэх холбогдох журам
- Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам

8.5.1.3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр болон холбогдох журмын дагуу хэрэгжүүлнэ.
Боловсролын үйлчилгээ үзүүлэх үндсэн үйл явцад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1. Багшлах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх;
2. Суралцагчийн суралцах үйл ажиллагааг чиглүүлэх, дэмжих;
3. Сургалтын зохион байгуулалт, бүртгэл, мэдээлэл, захиргааны дэмжлэг үзүүлэх;
4. Суралцагчийн сургалтын явц, ахиц, үр дүнг үнэлэх;
5. Суралцагчдад шаардлагатай зөвлөгөө, хөгжлийн болон бусад дэмжих үйлчилгээ үзүүлэх.

Эдгээр үйл явцыг холбогдох нэгжүүд чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж, хяналт тавина.
Холбогдох баримт бичиг:

- Сургалтын тэнхимийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/001, Хавсралт IX)
- Багшлахуй ба суралцахуйн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/002, Хавсралт X)
- Оюутны хөгжлийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/006, Хавсралт XIV)
- Шалгалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/008, Хавсралт XVI)
- Эрдэм шинжилгээний үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/013, Хавсралт XX)
- Оюутны суралцахуйн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/016, Хавсралт XXIII)

8.5.1.4. Суралцагчийн дүнгийн үнэлгээ

МУИС нь суралцагчийн мэдлэг, ур чадвар, суралцахуйн үр дүнг сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагааны журмаар тогтоосон үнэлгээний арга, шалгуурын дагуу үнэлнэ.
Үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Үнэлгээний арга, шалгуурыг хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулах;
2. Үнэлгээний шалгуур, онооны системийг суралцагчдад мэдээлэх;
3. Суралцагчийн гүйцэтгэл болон олгосон үнэлгээний хоорондын уялдааг нотлох боломжийг бүрдүүлэх;
4. Үнэлгээний үр дүнг сургалтын мэдээллийн системд холбогдох журмын дагуу бүртгэх;
5. Үнэлгээтэй холбоотой баримтжуулсан мэдээллийг тогтоосон хугацаанд хадгалах.

Сургалтын мэдээллийн систем, үнэлгээний материал болон холбогдох бүртгэлийг суралцагчийн үнэлгээний үр дүнг хянах, шаардлагатай тохиолдолд мөшгөн тогтооход ашиглана.
Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- Шалгалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/008)
- Сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр
- Суралцагчийн үнэлгээний холбогдох бүртгэл, мэдээллийн систем

8.5.1.5. Үнэлгээний үр дүнг баталгаажуулах, мэдээлэх

МУИС нь суралцагчийн үнэлгээний үр дүнг холбогдох журмын дагуу баталгаажуулж, суралцагчдад мэдээлнэ.

Үнэлгээний үр дүнг баталгаажуулах, мэдээлэх үйл ажиллагаанд дараах шаардлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үнэлгээний үр дүн, дүнгийн мэдээллийг суралцагчид сургалтын мэдээллийн систем болон бусад тохиромжтой сувгаар хүргэх;
2. Суралцагч өөрийн гүйцэтгэл, үнэлгээний үр дүнтэй танилцах боломжийг бүрдүүлэх;
3. Суралцагч үнэлгээтэй холбоотой санал, хүсэлт, гомдол гаргах, дахин хянуулах боломжийг холбогдох журмын дагуу хангах;
4. Үнэлгээний үр дүнг хянан үзсэн, өөрчилсөн тохиолдолд шийдвэрийн үндэслэл болон өөрчлөлтийг баримтжуулах;
5. Эцсийн үнэлгээний үр дүн, холбогдох шийдвэр, бүртгэлийг тогтоосон хугацаанд хадгалах.

Үнэлгээний мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, нууцлал, хүртээмжийг холбогдох журам болон мэдээллийн системийн зохицуулалтаар хангана.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- Шалгалтын үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/008)
- Суралцагчийн үнэлгээ, дүнгийн мэдээллийн холбогдох бүртгэл
- МУИС-ийн албан хэрэг хөтлөлт, баримтжуулсан мэдээллийн хяналтын холбогдох журам

8.5.1.6. Тусгай хэрэгцээт боловсролын нэмэлт шаардлага

МУИС нь тусгай хэрэгцээт суралцагчдын суралцах эрх, тэгш боломж, сургалтын хүртээмжийг хангах зорилгоор суралцагчийн хэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн шаардлага, боломжит нөөцөд үндэслэн зохистой тохируулга, дэмжих үйлчилгээг хэрэгжүүлнэ.

Сургалт, суралцах үйл ажиллагааны хүрээнд суралцагчийн онцлогт нийцсэн заах арга зүй, сургалтын материал, бие даан суралцахыг дэмжих арга хэрэгслийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Суралцагчийн үнэлгээнд суралцахуйн үр дүн, үнэлгээний шударга байдлыг хадгалан, суралцагчийн хэрэгцээнд нийцсэн тохируулгыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлнэ.

МУИС нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Сургалт, судалгааны орчин, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх;
2. Суралцагчийн хэрэгцээнд нийцсэн сургалтын тохируулга, туслах хэрэгсэл, технологийн боломжийг бүрдүүлэх;
3. Суралцах үйл ажиллагааг дэмжих дэд бүтэц, орчныг сайжруулах;
4. Суралцагчдад мэдээлэл, зөвлөгөө, хөгжлийн болон бусад дэмжих үйлчилгээ үзүүлэх;
5. Суралцагчийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн холбогдох нэгжүүдийн хамтын ажиллагааг зохион байгуулах.

Суралцагчийн хэрэгцээ, боломжид үндэслэн цахим хэлбэрийн сургалтын материал ашиглах, шалгалтын хугацаанд тохируулга хийх, тохиромжтой суудал, сургалтын орчин сонгох, сургалтын материалтай урьдчилан танилцах, туслах хэрэгсэл ашиглах зэрэг зохистой тохируулгыг авч үзнэ.

МУИС нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хичээл сонголт, дотуур байр, номын сан, сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад дэмжих үйлчилгээний хүртээмжийг холбогдох журам, зохицуулалтын дагуу хангахад анхаарна.

Сургалтын материал, цахим мэдээллийн хүртээмжийг сайжруулахдаа холбогдох олон улсын зөвлөмж, хүртээмжийн шаардлагыг харгалзан үзнэ.

Тусгай хэрэгцээт суралцагчдад үзүүлсэн дэмжлэг, тохируулгын үр нөлөөг холбогдох нэгжүүд хянан үзэж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлнэ.

8.5.2. Тэмдэглэгээ ба мөшгөх боломж

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгжилт, үр дүнг шаардлагатай үе шатанд таних, хянах, мөшгөн тогтоох боломжийг холбогдох бүртгэл, мэдээллийн систем болон баримтжуулсан мэдээллээр хангана.

Тэмдэглэгээ, мөшгөх боломжийг дараах үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Суралцагчийн элсэлт, бүртгэл, хичээл сонголт, сургалтын явц, үнэлгээ, төгсөлтийн мэдээлэл;
2. Сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээ, шинэчлэл;
3. Багшийн хичээл заалт, сургалтын үйл ажиллагааны бүртгэл, гүйцэтгэл;
4. Ажилтны чиг үүрэг, ажлын гүйцэтгэлтэй холбоотой холбогдох бүртгэл;
5. Үйл ажиллагааны хяналт, үнэлгээ, гарсан шийдвэр, хэрэгжүүлсэн арга хэмжээ.

Мөшгөх шаардлагатай мэдээллийг холбогдох мэдээллийн систем, бүртгэл, тайлан болон бусад баримтжуулсан мэдээллээр баталгаажуулж, тогтоосон хугацаанд хадгална.

8.5.3. Сонирхогч талын өмч

МУИС нь өөрийн эзэмшил, ашиглалт, хяналтад байгаа суралцагч болон бусад сонирхогч талуудын өмчийг таних, хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Сонирхогч талын өмчид эд хөрөнгө, тоног төхөөрөмж, сургалтын материал, баримт бичиг, оюуны өмч, хувийн мэдээлэл болон бусад холбогдох өмч хамаарч болно.

Сонирхогч талын өмч алдагдсан, гэмтсэн, ашиглахад тохиромжгүй болсон тохиолдолд холбогдох этгээдэд мэдээлж, байгууллагын журмын дагуу шаардлагатай арга хэмжээг авна.

Тухайн тохиолдол, авсан арга хэмжээний баримтжуулсан мэдээллийг холбогдох нэгж хадгална.

Оюуны өмч, хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмын дагуу хамгаална.

Холбогдох баримт бичиг:

- Оюутны хотхоны үйлчилгээний үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/005, Хавсралт XIII)
- МУИС-ийн мэдээллийн аюулгүй байдлын бодлого
- Өмч, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын холбогдох журам

8.5.4. Хамгаалалт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгжилтийн явцад бий болсон гаралт, баримтжуулсан мэдээлэл болон холбогдох материалын шаардлагад нийцсэн байдлыг хадгалах зорилгоор зохих хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хамгаалалтад шаардлагатай тохиолдолд таних тэмдэглэгээ, хадгалалт, мэдээллийн хамгаалалт, дамжуулалт, архивлалт болон бусад тохиромжтой арга хэмжээ хамаарна.

Сургалтын материал, үнэлгээний баримт, суралцагчийн бүртгэл, боловсролын баримт бичиг болон бусад холбогдох мэдээллийг тогтоосон шаардлагын дагуу хадгалж, хамгаална.

8.5.5. Суралцагчдын өгөгдлийн хамгаалалт, ил тод байдал

МУИС нь суралцагчдын хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалах болон холбогдох этгээдэд мэдээлэх үйл ажиллагааг хууль тогтоомж, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, холбогдох журмын дагуу зохицуулна.

Суралцагчдын өгөгдлийн хамгаалалтын хүрээнд дараах асуудлыг тодорхойлно. Үүнд:

1. Цуглуулах, боловсруулах суралцагчийн мэдээллийн төрөл, зорилго;
2. Мэдээллийг боловсруулах, хадгалах хэлбэр, байршил;
3. Мэдээлэлд хандах эрх бүхий ажилтан, албан тушаалтан;
4. Мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах нөхцөл, эрх зүйн үндэслэл;
5. Мэдээллийг хадгалах хугацаа, архивлах болон устгах зохицуулалт;
6. Суралцагч өөрийн мэдээлэлтэй танилцах, хуульд заасан үндэслэлээр засуулах, шинэчлэх боломж.

Суралцагчийн хувийн мэдээллийг боловсруулахдаа хууль тогтоомжид заасан зөвшөөрөл болон бусад эрх зүйн үндэслэлийг баримтална.
Мэдээллийн системд хандах эрхийг ажил үүргийн хэрэгцээ, эрх хэмжээтэй уялдуулан тогтоож, зөвшөөрөлгүй хандалт, мэдээлэл алдагдах, өөрчлөгдөхөөс хамгаалах зохих арга хэмжээг хэрэгжүүлнэ.
Мэдээллийн аюулгүй байдлын зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох журмын дагуу бүртгэж, шалган шийдвэрлэж, шаардлагатай залруулах арга хэмжээг авна.
Холбогдох баримт бичиг:

- Мэдээллийн технологийн үйл явцын гарын авлага (NUM/EOMS/PFC/010, Хавсралт XVII)
- МУИС-ийн мэдээллийн аюулгүй байдлын бодлого
- Хувийн мэдээлэл хамгаалах холбогдох журам

8.5.6. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийн хяналт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгжилтийн явцад гарсан өөрчлөлтийг шаардлагад нийцсэн байдлыг хадгалах зорилгоор хянан үзэж, зохицуулна.
Өөрчлөлтийн хэрэгцээ, үндэслэл, хамрах хүрээ, боломжит нөлөөллийг үнэлж, холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.
Өөрчлөлтийн хяналтын үр дүн, өөрчлөлтийг зөвшөөрсөн албан тушаалтан, хэрэгжүүлэхээр тогтоосон арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хадгална.
Холбогдох баримт бичиг:

- Өөрчлөлтийн менежментийн журам (NUM/EOMS/PRO/006, Хавсралт VII)

8.6. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтоосон шаардлагад нийцсэн эсэхийг төлөвлөсөн хяналт, үнэлгээний арга хэмжээгээр баталгаажуулна.
Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг холбогдох шалгуур, шаардлагыг хангаж, эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, шийдвэр гарсны үндсэн дээр дараагийн үе шатанд шилжүүлэх буюу суралцагч, бусад холбогдох этгээдэд хүргэнэ.
Төлөвлөсөн хяналт, үнэлгээ бүрэн хийгдээгүй тохиолдолд холбогдох эрх бүхий этгээд, шаардлагатай бол суралцагч болон бусад холбогдох талын зөвшөөрөлгүйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахгүй.
МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргасан тухай дараах баримтжуулсан мэдээллийг хадгална. Үүнд:

1. Хүлээн авах шалгуур, шаардлагыг хангасныг нотлох мэдээлэл;
2. Бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий этгээдийг мөшгөн тогтоох боломжтой мэдээлэл.

8.7. Үл тохирол бүхий гаралтын хяналт

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон холбогдох үйл явцын гаралт тогтоосон шаардлагад нийцээгүй тохиолдолд түүнийг таних, хянах, зориулалтын бусаар ашиглах буюу хүргэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
Сургалтын хөтөлбөр, элсэлт, сургалт, үнэлгээ, төгсөлт, судалгаа болон бусад холбогдох үйл ажиллагаанд илэрсэн үл тохирол бүхий гаралтыг **“Үл тохирол бүхий гаралтын журам” (NUM/EOMS/PRO/005)**-ын дагуу хянан шийдвэрлэнэ.
Үл тохирол бүхий гаралтын шинж чанар, үзүүлэх нөлөөлөлд тохируулан дараах арга хэмжээнээс нэг буюу хэд хэдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үл тохирлыг залруулах;
2. Холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээний ашиглалт, хүргэлтийг хязгаарлах, түр зогсоох, буцаах;
3. Шаардлагатай тохиолдолд суралцагч болон бусад холбогдох сонирхогч талуудад мэдээлэх;

4. Зөвшөөрөгдөх боломжтой тохиолдолд эрх бүхий этгээдээс онцгой зөвшөөрөл авч, тодорхой нөхцөлтэйгөөр хүлээн зөвшөөрөх.

Үл тохирлыг залруулсны дараа тогтоосон шаардлагад нийцсэн эсэхийг дахин хянан баталгаажуулна.

МУИС нь үл тохирол бүхий гаралтын талаар дараах баримтжуулсан мэдээллийг хадгална. Үүнд:

1. Илэрсэн үл тохирлын тодорхойлолт;
2. Авсан залруулга болон бусад арга хэмжээ;
3. Олгосон онцгой зөвшөөрөл, холбогдох нөхцөл;
4. Үл тохирлыг шийдвэрлэх эрх бүхий этгээд, гарсан шийдвэр.

Үл тохирол бүхий гаралтын хяналтын үр дүнг шаардлагатай тохиолдолд залруулах арга хэмжээ, эрсдэлийн үнэлгээ болон НМТ-ийн сайжруулалтын үйл ажиллагаанд ашиглана.

Холбогдох баримт бичиг:

- Үл тохирол бүхий гаралтын журам (NUM/EOMS/PRO/005)

БҮЛЭГ 9. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

9.1. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээ

9.1.1. Ерөнхий зүйл

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) гүйцэтгэл, үр нөлөө болон боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагад нийцсэн байдлыг үнэлэх зорилгоор мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлнэ. Эдгээр үйл ажиллагаа нь дараах зорилготой. Үүнд:

1. НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөөг үнэлэх;
2. Чанарын бодлого, стратегийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө болон холбогдох шаардлагын хэрэгжилтийг хянах;
3. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх;
4. Эрсдэл, боломж болон сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлох;
5. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, тасралтгүй сайжруулалтыг дэмжих.

МУИС нь мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг төлөвлөхдөө дараах асуудлыг тодорхойлно. Үүнд:

- Мониторинг хийх, хэмжих шаардлагатай үйл явц, үйл ажиллагаа, үзүүлэлт;
- Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний арга, шалгуур;
- Гүйцэтгэлийн зорилтот түвшин, шаардлагатай тохиолдолд хүлээн авах шалгуур;
- Мониторинг, хэмжилт хийх хугацаа, давтамж;
- Үр дүнд дүн шинжилгээ хийх, үнэлэх хугацаа, давтамж;
- Хариуцах нэгж, албан тушаалтан;
- Үр дүнг тайлагнах, ашиглах болон баримтжуулах зохицуулалт.

МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль, хүрээлэн, төв, газар, нэгжүүд нь чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд мониторинг, үнэлгээ хийж, холбогдох тайлан, мэдээллийг бүрдүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь байгууллагын холбогдох дүрэм, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тус газар нь эрсдэлд суурилсан хандлагыг харгалзан төлөвлөгөөт болон шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт, үнэлгээ, аудит хэрэгжүүлж, үр дүнг холбогдох удирдлага, нэгжүүдэд тайлагнана.

Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үр дүнг байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, эрсдэлийг бууруулах, залруулах арга хэмжээ тодорхойлох болон удирдлагын дүн шинжилгээнд ашиглана.

МУИС нь мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн нотолгоо болох баримтжуулсан мэдээллийг холбогдох шаардлагын дагуу хадгална.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн Хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээний журам
- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө (2025–2030)
- Холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын төлөвлөгөө, тайлан
- НМТ-ийн мониторинг, хэмжилт, үнэлгээний холбогдох бүртгэл

9.1.2. Суралцагч, бусад үр шим хүртэгч талууд болон ажилтнуудын сэтгэл ханамж

9.1.2.1. Сэтгэл ханамжийн мониторинг

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургалтын орчин, байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмж болон сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт хангагдаж буй байдлыг үнэлэх зорилгоор суралцагч, ажилтан, төгсөгч, ажил олгогч болон бусад

холбогдох талуудын санал хүсэлт, сэтгэл ханамжийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

Сэтгэл ханамжийн мониторингийг судалгаа, ярилцлага, санал хүсэлт, гомдлын мэдээлэл, сургалтын болон үйлчилгээний үнэлгээ, бусад тохиромжтой аргаар хэрэгжүүлнэ.

Сэтгэл ханамжийн мониторингийн үндсэн чиглэлд дараах асуудал хамаарна.

№	Мониторингийн чиглэл	Үндсэн арга
1	Суралцагчийн сэтгэл ханамж	Сургалт, хичээл, үйлчилгээ, сургалтын орчны судалгаа, санал хүсэлт
2	Ажилтны сэтгэл ханамж	Ажлын орчин, байгууллагын удирдлага, хүний нөөцийн бодлого, хөгжлийн боломжийн судалгаа
3	Төгсөгчдийн үнэлгээ	Төгсөгчдийн сэтгэл ханамж, хөдөлмөр эрхлэлт, эзэмшсэн чадамжийн судалгаа
4	Ажил олгогчдын үнэлгээ	Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, чадамж, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээний судалгаа
5	Бусад сонирхогч талуудын санал хүсэлт	Хамтрагч байгууллага, зочин, үйлчлүүлэгчдийн санал хүсэлт, үйлчилгээний үнэлгээ

Судалгааны арга, давтамж, хамрах хүрээ, хариуцах нэгжийг холбогдох журам, үйл ажиллагааны төлөвлөгөө болон судалгааны удирдамжаар тодорхойлно.

а) Суралцагчийн сэтгэл ханамж

МУИС нь суралцагчдын сургалтын хөтөлбөр, хичээл, багшлах үйл ажиллагаа, сургалтын орчин, оюутны хөгжил, үйлчилгээ, дотуур байр болон бусад дэмжих үйлчилгээний талаарх санал хүсэлт, сэтгэл ханамжийг холбогдох нэгжүүдээр дамжуулан судална.

Судалгааны үр дүнг сургалтын чанар, үйлчилгээний хүртээмж, суралцагчийн оролцоо болон дэмжих үйл ажиллагааг сайжруулахад ашиглана.

б) Сургалтын хөтөлбөрийн оролцогч талуудын үнэлгээ

МУИС нь сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, төгсөгчдийн эзэмшсэн чадамж болон хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээтэй нийцсэн байдлыг үнэлэхдээ суралцагч, төгсөгч, ажил олгогч болон бусад холбогдох талуудын санал хүсэлт, судалгааны үр дүнг ашиглана.

Эдгээр мэдээлэл нь сургалтын хөтөлбөрийн дотоод үнэлгээ, шинэчлэл, чанарын баталгаажуулалт болон сайжруулалтын үндэслэл болно.

в) Ажилтны сэтгэл ханамж

МУИС нь багш, ажилтнуудын ажлын орчин, удирдлага, байгууллагын харилцаа, хүний нөөцийн бодлого, урамшуулал, мэргэжлийн хөгжлийн боломж болон бусад холбогдох асуудлаарх сэтгэл ханамжийг судалж, үнэлнэ.

Судалгааны үр дүнг хүний нөөцийн бодлого, ажлын орчин, байгууллагын соёл болон ажилтны оролцоог сайжруулахад ашиглана.

г) Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамж

МУИС нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжийн хэрэглээ болон ажил олгогчдын хэрэгцээ, хүлээлтийг судалж, үнэлнэ.

Судалгааны үр дүнг сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, суралцахуйн үр дүнгийн үнэлгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах үйл ажиллагаанд ашиглана.

д) Бусад сонирхогч талуудын сэтгэл ханамж

МУИС нь хамтрагч байгууллага, зочин, үйлчлүүлэгч болон бусад холбогдох сонирхогч талуудын санал хүсэлтийг тохиромжтой арга, сувгаар хүлээн авч, шаардлагатай тохиолдолд дүн шинжилгээ хийнэ.

Эдгээр мэдээллийг хамтын ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж болон байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад ашиглана.

Сэтгэл ханамжийн мониторингийн үр дүнг холбогдох нэгжүүд нэгтгэн дүгнэж, шаардлагатай сайжруулах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтийг хянана.

Судалгааны үр дүн, дүн шинжилгээ, гарсан шийдвэр болон хэрэгжүүлсэн арга хэмжээний баримтжуулсан мэдээллийг холбогдох шаардлагын дагуу хадгална.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- Суралцагч, ажилтан, төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, шинэчлэлийн холбогдох тайлан
- Санал хүсэлт, өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээлэл

9.1.2.2. Өргөдөл, гомдлыг хянах

МУИС нь суралцагч, ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх, хариу өгөх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрэм, журмын дагуу хэрэгжүүлнэ.

Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд дараах үе шатыг баримтална. Үүнд:

1. Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах;
2. Бүртгэх, холбогдох нэгжид шилжүүлэх, шийдвэрлэлтийн явцыг мөшгөх;
3. Асуудлын агуулга, хамрах хүрээ, шийдвэрлэх эрх хэмжээг тодорхойлох;
4. Холбогдох мэдээлэл, нотлох баримтыг судалж, шалгах;
5. Эрх бүхий этгээдээс шийдвэр гаргаж, өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдэх;
6. Шийдвэрлэлтийг бүртгэж, хаах;
7. Холбогдох баримтжуулсан мэдээллийг хадгалах.

МУИС нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ шударга, ил тод, бодитой, хараат бус байдлыг хангаж, өргөдөл, гомдол гаргагчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаална.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, давтагдаж буй асуудал, үл тохирол болон сайжруулах боломжийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэр, хариу мэдэгдэл болон холбогдох нотлох баримтыг тогтоосон шаардлагын дагуу хадгална.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн Албан хэрэг хөтлөлтийн журам
- Өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх холбогдох журам
- Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн тайлан

9.1.3. Бусад мониторинг, хэмжилтийн хэрэгцээ

МУИС нь боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын ахиц дэвшил болон байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зорилгоор шаардлагатай мониторинг, хэмжилтийг хэрэгжүүлнэ.

Мониторинг, хэмжилтийн хүрээнд дараах асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, хэрэгжилт, шинэчлэл;
2. Суралцагчийн сургалтын ачаалал, ахиц дэвшил, сурлагын амжилт, төгсөлтийн түвшин;
3. Суралцагчийн үнэлгээний арга, шалгуур, үр дүнтэй байдал;
4. Суралцагч болон бусад үр шим хүртэгч талуудын хөтөлбөр, үйлчилгээний талаарх санал хүсэлт;
5. Сургалтын орчин, дэд бүтэц, дэмжих үйлчилгээний хүртээмж, тохиромжтой байдал;
6. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний үр дүн, байгууллагын нийгэмд үзүүлэх нөлөөлөл.

МУИС нь суралцагч, төгсөгч, ажил олгогч болон бусад холбогдох талуудаас боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, суралцахуйн үр дүн, байгууллагын нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар санал хүсэлт авч, шаардлагатай тохиолдолд нийтэд мэдээлнэ.
Санал хүсэлт цуглуулах үйл ажиллагааны хамрах хүрээ, оролцооны түвшин, мэдээллийн хүрэлцээг хянан үзэж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээ авна.
Мониторинг, хэмжилтийн үр дүнг сургалтын хөтөлбөр, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагааны сайжруулалтад ашиглаж, холбогдох баримтжуулсан мэдээллийг хадгална.

9.1.4. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний арга

МУИС нь мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний зорилго, хамрах хүрээ, шалгуур, аргачлал болон гүйцэтгэлийн зорилтот түвшнийг тодорхойлно.
Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд дараах шаардлагыг харгалзан үзнэ. Үүнд:

1. Үнэлгээний зорилго, хамрах хүрээ, шалгуур, мэдээлэл цуглуулах аргыг тодорхойлох;
2. Үнэлгээнд хамрагдах болон үр дүн нь нөлөөлөх сонирхогч талуудыг тодорхойлох;
3. Үнэлгээ хийх ажилтны чадамж, бодитой, шударга байдлыг хангах;
4. Мэдээлэл, нотлох баримтын найдвартай, үнэн зөв, хүрэлцээтэй байдлыг хангах;
5. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгжилтэд нөлөөлөх сургалтын орчин болон бусад нөхцөлийг харгалзан үзэх;
6. Үнэлгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг ашигласан арга, шалгуур, нотолгоонд үндэслэн тайлагнах.

Мониторинг, хэмжилт, үнэлгээний аргачлалыг тухайн үйл ажиллагааны онцлог, зорилго, шаардлагад нийцүүлэн сонгож, хэрэгжүүлнэ.
Үнэлгээний тайланд зорилго, хамрах хүрээ, ашигласан арга, шалгуур, гол үр дүн, дүгнэлт, шаардлагатай зөвлөмжийг тодорхой тусгана.

9.1.5. Дүн шинжилгээ ба үнэлгээ

МУИС нь мониторинг, хэмжилт болон бусад холбогдох эх үүсвэрээс цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөө болон сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлнэ.
Дүн шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараах асуудлыг тодорхойлоход ашиглана. Үүнд:

1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагад нийцсэн байдал;
2. Суралцагч болон бусад үр шим хүртэгч талуудын сэтгэл ханамж;
3. Ажилтнуудын сэтгэл ханамж;
4. НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөө;
5. Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн;
6. Эрсдэл, боломжийг шийдвэрлэхээр авсан арга хэмжээний үр нөлөө;
7. Гаднын нийлүүлэгчдийн гүйцэтгэл;
8. НМТ болон байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээ.

Дүн шинжилгээ, үнэлгээний үр дүнг холбогдох удирдлага, нэгжүүдэд тайлагнаж, төлөвлөлт, шийдвэр гаргалт, залруулах арга хэмжээ болон удирдлагын дүн шинжилгээнд ашиглана.
Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж болон холбогдох баримтжуулсан мэдээллийг байгууллагын баримт бичгийн хяналт, архивын шаардлагын дагуу хадгална.

9.2. Дотоод аудит

МУИС нь НМТ-ийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх зорилгоор төлөвлөсөн давтамжтайгаар дотоод аудит хэрэгжүүлнэ.
Дотоод аудит нь НМТ дараах шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд чиглэнэ. Үүнд:

1. ISO 21001:2018 болон ISO 9001:2015 стандартын холбогдох шаардлага;
2. МУИС-ийн НМТ-д тогтоосон дотоод шаардлага;
3. Холбогдох дүрэм, журам, үйл явцын зохицуулалт.

МУИС нь аудитын хөтөлбөрийг боловсруулахдаа аудит хийх үйл явцын ач холбогдол, байгууллагад нөлөөлөх өөрчлөлт, өмнөх аудитын үр дүн болон холбогдох эрсдэлийг харгалзан үзнэ.
Аудитын хөтөлбөрт аудитын давтамж, арга, хариуцлага, төлөвлөлтийн шаардлага, тайлагнах зохицуулалтыг тодорхойлно.
Аудит бүрийн шалгуур, хамрах хүрээг тогтоож, аудиторыг сонгох, аудит хийх үйл ажиллагаанд бодитой, шударга, хараат бус байдлыг хангана. Аудитор өөрийн гүйцэтгэсэн ажлыг аудитлахгүй байх зарчмыг баримтална.
Дотоод аудитыг шаардлагатай чадамжтай, холбогдох сургалт, дадлага эзэмшсэн аудиторууд гүйцэтгэнэ.
Аудитын үр дүнг холбогдох удирдлага, аудитад хамрагдсан нэгжүүдэд тайлагнана.
Аудитаар илэрсэн үл тохирол, сайжруулах шаардлагатай асуудлын талаар холбогдох нэгжүүд шаардлагатай залруулга, залруулах арга хэмжээг зохих хугацаанд хэрэгжүүлнэ.
Залруулах арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөг холбогдох журмын дагуу хянаж, үнэлнэ.
Аудитын хөтөлбөрийн хэрэгжилт, аудитын үр дүн болон холбогдох нотолгооны баримтжуулсан мэдээллийг хадгална.

Холбогдох баримт бичиг:

- Дотоод аудитын журам (NUM/EOMS/PRO/004, Хавсралт XXX)
- Дотоод аудитын хөтөлбөр, төлөвлөгөө
- Дотоод аудитын тайлан, үл тохирлын бүртгэл
- Залруулах арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөний үнэлгээ

9.3. Удирдлагын дүн шинжилгээ

9.3.1. Ерөнхий зүйл

МУИС-ийн дээд удирдлага нь НМТ-ийн тохиромжтой, хүрэлцээтэй, үр нөлөөтэй байдал болон байгууллагын стратегийн чиглэлтэй нийцсэн байдлыг хангах зорилгоор төлөвлөсөн давтамжтайгаар удирдлагын дүн шинжилгээ хийнэ.
Удирдлагын дүн шинжилгээг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт дүн шинжилгээ хийж болно.
Удирдлагын дүн шинжилгээ нь дараах зорилготой. Үүнд:

1. НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөөг үнэлэх;
2. Чанарын бодлого, зорилт болон стратегийн чиглэлтэй нийцсэн байдлыг хянан үзэх;
3. Байгууллагын үйл ажиллагаа, нөөц, эрсдэл, боломжийн удирдлагыг үнэлэх;
4. Сайжруулах боломж, шаардлагатай өөрчлөлт, нөөцийн хэрэгцээг тодорхойлох.

9.3.2. Удирдлагын дүн шинжилгээний оролт

Удирдлагын дүн шинжилгээнд дараах мэдээллийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Өмнөх удирдлагын дүн шинжилгээнээс гарсан шийдвэр, арга хэмжээний хэрэгжилт;
2. НМТ-д хамаарах гадаад, дотоод асуудлын өөрчлөлт;
3. Сурагчид, ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудын санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааны үр дүн;
4. Чанарын зорилт, стратегийн зорилтын хэрэгжилт;
5. Үйл явцын гүйцэтгэл, боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлагад нийцсэн байдал;
6. Үл тохирол, залруулах арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөө;
7. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үр дүн;
8. Дотоод болон гадаад аудитын үр дүн;
9. Гаднын нийлүүлэгчдийн гүйцэтгэл;
10. Нөөцийн хүрэлцээ, тохиромжтой байдал;
11. Эрсдэл, боломжийг шийдвэрлэхээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөө;
12. НМТ болон байгууллагын үйл ажиллагааг сайжруулах боломж.

Удирдлагын дүн шинжилгээний оролтын мэдээллийг холбогдох нэгжүүд чиг үүргийнхээ хүрээнд бүрдүүлж, дүн шинжилгээнд танилцуулна.

9.3.3. Удирдлагын дүн шинжилгээний гаралт

Удирдлагын дүн шинжилгээний үр дүнд дараах асуудлаар шийдвэр, арга хэмжээ тодорхойлно. Үүнд:

1. НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах боломж, арга хэмжээ;
2. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйл явцын сайжруулалт;
3. НМТ-д оруулах шаардлагатай өөрчлөлт;
4. Чанарын зорилт, холбогдох төлөвлөгөөг шинэчлэх хэрэгцээ;
5. Хүний нөөц, санхүү, дэд бүтэц, технологи болон бусад нөөцийн хэрэгцээ.

Удирдлагын дүн шинжилгээний хурлаас гарсан шийдвэр, хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах нэгж, хэрэгжүүлэх хугацаа болон шаардлагатай нөөцийг холбогдох баримтжуулсан мэдээлэлд тусгана.

Гарсан шийдвэр, арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох нэгжүүд хянаж, үр дүнг дараагийн удирдлагын дүн шинжилгээнд танилцуулна.

Удирдлагын дүн шинжилгээний үр дүн, гарсан шийдвэр, арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох нотолгооны баримтжуулсан мэдээллийг хадгална.

Холбогдох баримт бичиг:

- Менежментийн дүн шинжилгээний журам (NUM/EOMS/PRO/001, Хавсралт XXXI)
- Удирдлагын дүн шинжилгээний хурлын тэмдэглэл, шийдвэр
- Удирдлагын дүн шинжилгээний оролтын тайлан, мэдээлэл
- Удирдлагын дүн шинжилгээний шийдвэрийн хэрэгжилтийн бүртгэл

БҮЛЭГ 10. САЙЖРУУЛАЛТ

10.1. Ерөнхий зүйл

МУИС нь нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) гүйцэтгэл, үр нөлөөг дээшлүүлэх, боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, суралцагч болон бусад холбогдох сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг хангах зорилгоор сайжруулах боломжийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Сайжруулалтын үйл ажиллагаа нь дараах чиглэлийг хамарна. Үүнд:

1. Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах;
2. Суралцагч болон бусад холбогдох сонирхогч талуудын өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэх;
3. Үл тохирол, хүсээгүй үр дагаврыг залруулах, урьдчилан сэргийлэх, бууруулах;
4. НМТ-ийн гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах;
5. Сургалт, судалгаа, үйлчилгээ болон байгууллагын үйл явцад шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтийг хэрэгжүүлэх.

Сайжруулах боломжийг мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээ, дотоод болон гадаад аудит, удирдлагын дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, сонирхогч талуудын санал хүсэлт болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн тодорхойлно.

Сайжруулах арга хэмжээг холбогдох нэгжүүд чиг үүргийнхээ хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлж, үр дүнг хянан үнэлнэ.

10.2. Үл тохирол ба залруулах арга хэмжээ

МУИС нь НМТ-ийн үйл ажиллагаанд үл тохирол илэрсэн тохиолдолд түүний шинж чанар, үр дагаварт тохирсон залруулга болон залруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үл тохирол илэрсэн тохиолдолд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. **Үл тохиролд хариу үйлдэл үзүүлэх:**
   - Үл тохирлыг хянах, шаардлагатай залруулга хийх;
   - Үл тохирлоос үүссэн үр дагаврыг шийдвэрлэх.
2. **Үл тохирлын шалтгааныг тодорхойлох:**
   - Үл тохирлыг хянан үзэж, шалтгааныг шинжлэх;
   - Ижил төстэй үл тохирол байгаа эсэх, цаашид үүсэх боломжтой эсэхийг үнэлэх;
   - Үл тохирол дахин давтагдах, өөр үйл явцад үүсэхээс сэргийлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох.
3. **Залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх:**
   - Шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;
   - Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг хянан үнэлэх;
   - Шаардлагатай тохиолдолд эрсдэл, боломжийн үнэлгээг шинэчлэх;
   - Шаардлагатай тохиолдолд НМТ-ийн үйл явц, баримтжуулсан мэдээлэлд өөрчлөлт оруулах.

Залруулах арга хэмжээ нь илэрсэн үл тохирлын үр дагавар, эрсдэл, байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөлтэй тохирсон байна.

МУИС нь үл тохирлын шинж чанар, авсан арга хэмжээ болон залруулах арга хэмжээний үр дүнгийн нотолгоо болох баримтжуулсан мэдээллийг хадгална.

Холбогдох баримт бичиг:

- Залруулах арга хэмжээний журам (NUM/EOMS/PRO/003, Хавсралт XXXIII)
- Үл тохирол бүхий гаралтын журам (NUM/EOMS/PRO/005)
- Үл тохирол, залруулах арга хэмжээний бүртгэл
- Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

10.3. Тасралтгүй сайжруулалт

МУИС нь НМТ-ийн тохиромжтой, хүрэлцээтэй, үр нөлөөтэй байдлыг тасралтгүй сайжруулна.

Тасралтгүй сайжруулалтыг дараах үйл ажиллагааны үр дүнд үндэслэн хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мониторинг, хэмжилт, дүн шинжилгээ, үнэлгээний үр дүн;
2. Дотоод болон гадаад аудитын үр дүн;
3. Удирдлагын дүн шинжилгээний шийдвэр, зөвлөмж;
4. Суралцагч, ажилтан, төгсөгч, ажил олгогч болон бусад сонирхогч талуудын санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгаа;
5. Эрсдэл, боломжийн үнэлгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн;
6. Сургалтын хөтөлбөр, судалгаа, үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ.

Тасралтгүй сайжруулалтын хүрээнд дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг сайжруулах;
- Сургалт, судалгаа, үйлчилгээний үйл явцын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх;
- Суралцагч болон бусад холбогдох сонирхогч талуудын сэтгэл ханамж, оролцоог нэмэгдүүлэх;
- Хүсээгүй үр дагавар, үл тохирол, эрсдэлийг бууруулах;
- Байгууллагын чадавх, хүний нөөц, дэд бүтэц, технологи болон менежментийн үйл ажиллагааг сайжруулах.

Сайжруулах арга хэмжээг холбогдох нэгжүүд үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдлагын шийдвэр болон бусад зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Сайжруулалтын хэрэгжилт, үр дүнг хянан үнэлж, шаардлагатай тохиолдолд нэмэлт арга хэмжээ авна.

Сайжруулалтын үр дүнг байгууллагын төлөвлөлт, шийдвэр гаргалт болон НМТ-ийн дараагийн сайжруулалтын үйл ажиллагаанд ашиглана.

Холбогдох баримт бичиг:

- МУИС-ийн стратегийн төлөвлөгөө (2025–2030)
- Менежментийн дүн шинжилгээний журам (NUM/EOMS/PRO/001)
- Залруулах арга хэмжээний журам (NUM/EOMS/PRO/003)
- Эрсдэл, боломжийн удирдлагын журам (NUM/EOMS/PRO/007)
- Сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралтын дугаар	Баримт бичиг, мэдээллийн нэр	Баримт бичгийн код
I	НМТ-ийн хамрах хүрээ	—
II	НМТ-ийн үйл явцын дараалал ба харилцан үйлчлэл	—
III	НМТ-ийн бодлого	—
IV	МУИС-ийн байгууллагын бүтцийн диаграмм	—
V	НМТ-ийн зөвшөөрлийн мэдэгдэл	—
VI	Эрсдэл, боломжийн менежментийн журам	NUM/EOMS/PRO/007
VII	Өөрчлөлтийн менежментийн журам	NUM/EOMS/PRO/006
VIII	Нягтлах шаардлагатай	—
IX	Сургалтын тэнхимийн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/001
X	Багшлахуй ба суралцахуйн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/002
XI	Элсэлтийн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/003
XII	Төгсөгчидтэй хамтран ажиллах үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/004
XIII	Их сургуулийн хотхоны үйлчилгээний үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/005
XIV	Оюутны хөгжлийн үйлчилгээний үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/006
XV	Аж ахуй, эд хөрөнгийн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/007
XVI	Шалгалтын үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/008
XVII	Мэдээллийн технологийн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/010
XVIII	Маркетингийн үйл явцын гарын авлага	Кодыг нягтлах
XIX	Худалдан авалтын үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/012
XX	Эрдэм шинжилгээний үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/013
XXI	Спортын үйл явцын гарын авлага	Кодыг нягтлах
XXII	Стратегийн хөтөлбөрийн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/015
XXIII	Оюутны суралцахуйн үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/016
XXIV	Оюутны хөгжил, соёл, олон нийтийн үйл ажиллагааны гарын авлага	Кодыг нягтлах
XXV	Сургалтын үйл явцын гарын авлага	NUM/EOMS/PFC/018
XXVI	Маркетинг–элсэлтийн үйл явцын гарын авлага	Кодыг нягтлах
XXVII	Ашиглалтын үйл явцын гарын авлага	Кодыг нягтлах
XXVIII	Агуулах, нөөцийн үйл явцын гарын авлага	Кодыг нягтлах
XXIX	Баримтжуулсан мэдээллийн хяналтын журам	NUM/EOMS/PRO/002
XXX	Дотоод аудитын журам	NUM/EOMS/PRO/004
XXXI	Менежментийн дүн шинжилгээний журам	NUM/EOMS/PRO/001
XXXII	Үл тохирол бүхий гаралтын журам	NUM/EOMS/PRO/005
XXXIII	Залруулах арга хэмжээний журам	NUM/EOMS/PRO/003
XXXIV	МУИС-ийн стратегийн төлөвлөгөө (2025–2030)	—